



## “Өсвөрийн аврагч” бүлгийн сурагчийн гарын авлага

СОЁМБО нь тусгаар тогтносон, бүрэн эрхт, эртний түүх, соёл, төр ёсны арвин баялаг уламжлал бүхий эх оронч Монгол хүнийг илэрхийлнэ.

ТАВАН ХОШУУ нь тангараг өргөсөн аврагчийг илэрхийлнэ.

ГУРВАЛЖИН нь иргэний хамгаалалтын олон улсын таних тэмдэг, гурван өнгийн гар нь эв нэгдэл, хамтын ажиллагааг илэрхийлнэ.

НОМ нь Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсрол гэсэн утга санааг илэрхийлнэ.

ЭМЖСЭН ЧИДУН ЖИМСНИЙ МӨЧИР нь ялалт, амжилтыг бэлгэдэх ба мөнхөд оршихуйн утга санааг илэрхийлнэ.

ӨНГӨ нь гал, ус, эх дэлхийг бэлгэднэ.



## “Өсвөрийн аврагч” бүлгийн сурагчийн гарын авлага

Эмхэтгэн бэлтгэсэн:	Д. Сэржмядаг (PhD) Гамшиг судлалын хүрээлэн Проф. Ц. Хонгорзул (PhD) МУБИСургууль	
Хянан тохиолдуулсан:	Б. Ванчиндорж Н. Өлзиймаа Г. Дашдорж	Дэлхийн Зөн Монгол ОУБ Дэлхийн Зөн Монгол ОУБ Дэлхийн Зөн Монгол ОУБ
Номын дизайныг:	Т. Норов З. Цэрэндагва	

Ашгийн зорилгоор хуулбарлан олшруулахыг хориглоно.

ISBN- 978-99973-2-923-3



**USAID**  
FROM THE AMERICAN PEOPLE

**World Vision**  
АЗАСУН ЗӨН МОНГОЛ







Эхлээд намайг уншаарай	6	3.8. Гал түймрийн үед амь насаа хамгаалах арга, түлэгдэлтэнд үзүүлэх тусламж	68
Номын хөтөч	7	3.9. Ой хээрийн түймрийн үед авах арга хэмжээ, унтраах арга	71
Нэгдүгээр бүлэг. Өсвөрийн аврагч бүлгийн тухай	8	3.10. Зудын эрсдэл, түүнийг бууруулах арга	74
1.1. Бүлгээ хэрхэн байгуулах вэ?	10	3.11. Үерийн аюулаас хэрхэн хамгаалах вэ?	76
1.2. Бүлгийн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах вэ?	12	3.12. Гол мөрний усны осол, тусламж үзүүлэх арга	78
1.3. Бүлгээ хэрхэн хүчирхэг байлгаж, хөгжүүлэх вэ?	20	3.13. Химийн хортой болон аюултай бодисын аюулаас хамгаалах арга	82
Хоёрдугаар бүлэг. Өсвөрийн аврагч бүлгийн үйл ажиллагаа: Анхан түвшин	22	3.14. Төөрсөн үед өөрийгөө аврах арга	85
2.1. Гамшгийн тухай ойлголт	24	3.15. Тэсэж амьд үлдэх арга	87
2.2. Зарлан мэдээллийн дохио	25	Өөрийгөө шалгаарай	90
2.3. Гал түймэр хэрхэн гардаг вэ?	26	Хавсралт	
2.4. Ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга, тэмдэг тэмдэглэгээ	28	Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөлт	92-97
2.5. Ой, хээрийн түймэр, түүнээс сэргийлэх арга	31	Удирдамж боловсруулах загвар	
2.6. Хүчтэй салхи, шуурганы эрсдэлээс хамгаалах арга	33	Төсөл боловсруулах заавар	
2.7. Аянга, цахилгааны эрсдэлээс хамгаалах арга	36	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай картууд	
2.8. Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах арга	38	Өөрийгөө шалгаарай хэсгийн хариулт	
2.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах	42	Ашигласан материал	98
2.10. Гамшгийн үе дэх хүүхэд хамгаалал	43		
Өөрийгөө шалгаарай	46		
Гуравдугаар бүлэг. Өсвөрийн аврагч бүлгийн үйл ажиллагаа: Ахисан түвшин	48		
3.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	50		
3.2. Гамшгийн эрсдэлийн тухай	52		
3.3. Нэрвэгдэгсдийг аврах тусламж үзүүлэх, зөөх ажиллагаа	54		
3.4. Өрхийн бэлэн байдлын багц	58		
3.5. Онцгой байдлын алба	61		
3.6. Аврагч, гал сөнөөгч мэргэжил	63		
3.7. Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, гал унтраагуурыг ашиглах арга	65		



## ЭХЛЭЭД НАМАЙГ УНШААРАЙ

Хүүхдүүд та бүхэн эрүүл, аюулгүй орчинд сурч, амьдрах нөхцлийг өөрсдөө бий болгох чиглэлээр олон талт үйл ажиллагааг зохион байгуулж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, эрсдэлгүй нийгмийг бүтээхэд үнэтэй хувь нэмрээ оруулж чадна. Энэхүү үйл ажиллагаандаа бусад сурагчид, хамт олон, багш, эцэг, эх, орон нутгийн иргэдийг уриалан дуудаж оролцуулах зорилго бүхий, бүтээлч хүсэл эрмэлзэлтэй сурагчид сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан бүлгийг “Өсвөрийн аврагч” бүлэг гэнэ.

Энэ бүлэгт хамрагдсанаар хүүхдүүд та нар дараах мэдлэг, чадвар, хандлагыг олж авах болно.

1. Гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа болон болзошгүй байгалийн аюулт үзэгдэл, хүний санамсар болгоомжгүй байдлаас үүдсэн ослоос өөрийгөө болон бусдыг хамгаалах арга ухааныг эзэмшинэ.
2. Аливаа аюулт үзэгдэл, ослын үед өөртөө болон бусдад тусламж үзүүлэх, авран хамгаалах, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, түүний эрсдэлийг бууруулах чадвартай болно.
3. Болзошгүй эрсдэлийг олж тогтоох, урьдчилан сэргийлэх, шийдвэр гаргах, хамтран ажиллах хандлагыг “Өсвөрийн аврагч” бүлэг олгоно.

Хүүхдүүд та нар Өсвөрийн аврагч бүлэг байгуулж, түүний идэвхтэй гишүүн болж гамшгаас хамгаалах арга ухаанд суралцсанаар болзошгүй аюулт үзэгдэл, ослоос өөрийгөө төдийгүй гэр бүл, найз нөхдөө хамгаалах цаашлаад эх орон, эх дэлхийгээ хамгаалах агуу үйлсэд хувь нэмрээ оруулж чадна.

Иймд гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах энгийн арга ухаанд сургах зорилгоор та бүхэнд энэхүү товч гарын авлагыг толилуулж байна.

Энэхүү гарын авлагатай холбоотой санал хүсэлтээ Онцгой байдлын ерөнхий газар, Дэлхийн зөн Монгол ОУБ-ын хаягаар ирүүлбэл бид баяртай хүлээн авах болно.



## НОМЫН ХӨТӨЧ

Хүүхдүүдээ гарын авлагаа судлахдаа дараах таних тэмдгүүдийг ашиглаарай.



–Уншаад ярилцаарай



- Хамтдаа хийцгээе



- Үүнийг мэдэх үү



- Өөрийгөө шалгаарай



- Анхаарах асуудал









## 1.1. БҮЛГЭЭ ХЭРХЭН БАЙГУУЛАХ ВЭ?

Өсвөрийн аврагч бүлгийн гишүүний тоонд хязгаарлалт тогтоохгүй бөгөөд бага, дунд, ахлах ангийн сурагчдаас бүрдэх ба нэг сургуульд хэд хэдэн бүлэг байгуулж болно. Гэхдээ үйл ажиллагаагаа давхардуулахгүйгээр нарийн төлөвлөгөө гарган, нягт хамтарч ажиллах нь чухал.

### Бүлгийн үнэт зүйл

Бүлэг нь сургууль дээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад бүлэг, клуб, сурагчдын өөрөө удирдах байгууллагаас ялгарах үүднээс өөрийн нэр, лого, уриа, тангараг, бүч, зангиа, цамц, малгай, тэмдэг зэргийг өмсөж, хэрэглэх хэрэгтэй. Энэ нь нэг талаас бүлгийн гишүүд өөрсдөөрөө болон хийж буй ажлаараа, зорилгоороо бахархах, нөгөө талаас бүлэгийн үйл ажиллагаанд оролцогчдын итгэл үнэмшлийг төрүүлэх, тэдгээрт эх орон, ард түмнээ хайрлах үзэл санааг төлөвшүүлэх сайн талтай.



### Өсвөрийн аврагчийн тангараг

Монгол улсын иргэн би Өсвөрийн аврагч бүлгийн гишүүний хувьд аюулгүй амьдрах арга ухаанд суралцаж, бусдад зөв үлгэр дуурайлал болж эх дэлхий, эх орноо чин сэтгэлээсээ хайрлан хамгаалахаа тангараглаж байна.



### Бүлгийн бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь

Бүлгийн гишүүн сурагчид өөрсдөө бүлгийн ахлагч, салааны захирагч, өсвөрийн аврагч-гал сөнөөгч, өсвөрийн сувилагч, өсвөрийн холбоочин, өсвөрийн санхүүч, сурталчилгааны ажилтан гэх мэтээр гишүүдийнхээ хүсэл сонирхолд нь тулгуурлан ажил үүргээ хуваарилан томилгоожуулж ажиллах нь илүү тохиромжтой. Харин бүлгийн ахлагч, салааны захирагчийн үүрэг хүлээх гишүүдийг бүлгийн нийт гишүүдийн хурлаар санал хураалт явуулж сонгон шалгаруулаарай.

**Бүлгийн ахлагч:** Бүлгийн өдөр тутмын үйл ажиллагааг сургуулийн бүлгийн чиглүүлэгч багшийн шууд удирдлаган дор зохион байгуулах, заах аргын чадвар бүхий ахлах ангийн сурагч байх нь тохиромжтой.

**Салааны захирагч:** Бүлгийн гишүүдийн ажилд хяналт тавих, үйл ажиллагааг нь удирдах, ахлагчийн эзгүйд түүнийг орлох үүрэгтэй гишүүн юм.

**Өсвөрийн сувилагч:** Эмнэлгийн амилуулах суурь тусламж үзүүлэх дадал чадвар эзэмшин, бусдадаа зааж сургах хүсэлтэй гишүүд энэ үүргийг гүйцэтгэнэ.

**Өсвөрийн холбоочин:** Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон өдөр тутмын үйл ажиллагааны үед бусад байгууллагуудаас мэдээлэл



цуглуулах, бүлгийн гишүүдэд мэдээлэл түгээх үүрэг бүхий 2-3 гишүүн байна.

**Өсвөрийн сурталчилгааны ажилтан:** Сургууль, хамт олон, орон нутаг, иргэд олон нийтэд бүлгийн үйл ажиллагааг сурталчлах, түүхийн товчоог хөтлөх, мэдээллийн самбарыг хариуцах үүрэг бүхий хүүхдүүд байна.

**Өсвөрийн аврагч-гал сөнөөгч:** Эдгээр хүүхдүүд нь дээрх үүрэг гүйцэтгэх гишүүдээс бусад бүлгийн гишүүн хүүхдүүд байх бөгөөд бүлгийн үйл ажиллагааг гүйцэтгэх гол хүч болно.

Хүүхдүүдээ та нар энэхүү үүрэгт ажлаа улирал, эсвэл хагас жилээр ээлжлэн сольж шинэ зүйлд суралцах, өөрсдийн авьяас чадвараа хөгжүүлэн, удирдан зохион байгуулах, багаар ажиллах зэргээр өөрсдийн ур чадвараа байнга хөгжүүлээрэй.

### Бүлгийн зорилго, чиг үүрэг

“Өсвөрийн аврагч” бүлэг нь болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хүүхэд, өсвөр үеийнхнээ төлөөлж оролцох, гамшгийн аюулаас өөрийгөө болон бусдыг авран хамгаалах, тусламж үзүүлэх анхан шатны мэдлэг, чадвар эзэмших, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд багш, эцэг эх, олон нийтийг оролцохыг уриалах зорилготой ажиллана. Өөрөөр хэлбэл Өсвөрийн аврагч бүлгийн гол үйл ажиллагаа бол сургуулийн хүүхэд бүрийг өөрсдийн ажилдаа татан оруулж тэдгээрт гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах ажиллагааны талаар мэдлэг, чадвар эзэмшүүлэх, улмаар багш, эцэг, эх, орон нутгийн иргэдийг хамруулан арга хэмжээ зохион байгуулж тэдэнд аюулгүй амьдрах зөв хандлага, дадал төлөвшүүлэх явдал юм.

Чиг үүрэг нь:





## 1.2. БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРХЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ВЭ?

Хүүхдүүд та нар энэ бүлэгт нэгдсэнээр өөрсдийн авьяас, чадварыг нээн илрүүлж, хөгжих боломж бүрдэнэ. Бүлгээс зохион явуулах ажлуудад оролцсоноор төрөл бүрийн зохион байгуулалтын болон манлайллын, багаар ажиллах, шийдвэр гаргах, илтгэх, мэтгэлцэх зэрэг бусад чадваруудад суралцах нь хамгийн чухал. Энэ чадваруудыг бүлгийн үйл ажиллагаагаар дамжуулан эзэмшинэ.

Бүлгийн үйл ажиллагаа нь дараах үе шаттай явагдана.



### 1. Бүлгийн хурал зохион байгуулах нь





## Хурал зохион байгуулахдаа анхаарах асуудал:

Өсвөрийн аврагчдаа бүлгийн хурлыг зохион байгуулна гэдэг нь дан ганц удирдагч багш, эсвэл ахлагч гэх мэт сонгуульт ажилтай гишүүдийн хийх, шийдэх хэрэг биш, гишүүн бүрт хамаатай гэдгийг гишүүддээ сайн ойлгуулах нь зүйтэй.

Хурлын үеэр хэлэлцүүлэг явуулж болох бөгөөд ингэхдээ сургуулийн хэмжээний асуудлаас гадна орон нутгийн хэмжээний томоохон сэдвүүдийг сонгоход анхаарлаа хандуулаарай.

Бүлгийн хурал нь бусад хурал шиг нэг талаас удирдсан үйл ажиллагаа байх ёсгүй бөгөөд гишүүд өөрсдийн санаа, бодлыг нээлттэй чөлөөтэй хуваалцаж, тодорхой сэдвийн дагуу хэлэлцэж харилцан саналаа солилцох боломжийг бүрдүүлэх хэрэгтэй.



## 2. Бүлэг үйл ажиллагаагаа төлөвлөх нь:

Бүлгийнхээ үйл ажиллагааг маш нарийн төлөвлөх шаардлагатай. Гэхдээ үйл ажиллагаагаа төлөвлөхдөө үр дүнгүй олон зүйл төлөвлөхийн оронд цөөн хэдэн чанартай үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлбэл ач холбогдол сайтай байх болно.

Хүүхдүүдээ та нар жилийнхээ үйл ажиллагааг төлөвлөхдөө 1-р хавсралтад үзүүлсэн гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой дэлхий дахинд болон монгол оронд тэмдэглэдэг арга хэмжээтэй уялдуулж хийхийг хичээгээрэй. Тухайлбал, жил бүрийн 9 дүгээр сарын 14-ний өдөр нь Дэлхийн анхны тусламжийн өдөр байдаг тул энэ сэдвээр явуулах бүлгийнхээ үйл ажиллагааг энэ хугацаанд төлөвлөн явуулж болно. Учир нь энэ өдөр бүх эмнэлгийн ажилтнууд, Улаан загалмайн сайн дурын ажилтнууд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах тул та бүхний ажил амжилттай болоход сайнаар нөлөөлнө. Энэ мэтчилэн хавсралтад заасан тэмдэглэлт өдрүүдтэй бүлгийн ажлаа уялдуулан төлөвлөх нь их чухал юм. Боловсруулсан төлөвлөгөөндөө багш, эцэг эх, сургуулийн удирдлага, бусад холбогдох хүмүүсийн зөвлөгөөг аваарай.

Жилийн ажлын төлөвлөгөөгөө хийхдээ дараах хүснэгтийг ашиглаж болно.

	I сар	II сар	III сар	IV сар	V сар	VI сар	VII сар	VIII сар	IX сар	X сар	XI сар	XII сар
I долоо хоног												
II долоо хоног												
III долоо хоног												
IV долоо хоног												





Сайн бодитой хийгдсэн төлөвлөгөөтэй бол сургууль, орон нутгийн удирдлага болон дэмжих, хамтран ажиллах байгууллага, хүмүүстээ танилцуулж хамтран ажиллах санал тавихад хялбар байх болно.

### Бүлэг үйл ажиллагаа төлөвлөхдөө анхаарах асуудал

*Анхан түвшний Өсвөрийн аврагч бүлэг жилийнхээ ажлыг 3 долоо хоногтоо нэг уулзахаар төлөвлөж болно.*

*Ахисан түвшний Өсвөрийн аврагч бүлгийн хувьд 2 долоо хоногтоо нэг уулзахаар төлөвлөх боломжтой. Мөн өөрсдийн сурсан мэдсэн зүйлээ бүлгийн гишүүн биш хүүхдүүдэд зааж сургах ажлыг бүлгийн жилийн төлөвлөгөөндөө оруулан зохион байгуулаарай.*



### 3.Төлөвлөсөн үйл ажиллагааг зохион байгуулах нь:

Хүүхдүүд та нар төлөвлөсөн үйл ажиллагаагаа зохион байгуулахын өмнө удирдамжийг зайлшгүй /Удирдамжийн загварыг 2-р хавсралтаас харна уу/ боловсруулж сургуулийн удирдлага, багш болон хамтран зохион байгуулах албаны хүмүүст танилцуулж зөвлөгөө авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Ингэснээр та нарын зохион байгуулсан үйл ажиллагаа үр дүнтэй болохоос гадна сургууль, орон нутгийн гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах ажилд өөрсдийн хувь нэмрээ оруулсан үнэ цэнэтэй ажил болж чадна.

### 4.Бүлэг үйл ажиллагаагаа хянаж, үнэлэх нь:

Хүүхдүүд та нар аливаа үйл ажиллагааг үнэлж дүгнэж сурсан шүү дээ тиймээс өөрсдийн хийсэн бүтээснээ үнэлж дүгнэх нь цаашдын ажлаа сайжруулахад чинь ашиг тустайг бодолцоорой.

“ ..... ” Өсвөрийн аврагч бүлгийн ....-р улиралд хийсэн ажил

Ажлын нэр	Он, сар, өдөр	Удирдсан багш	Хамтран ажилласан	Санал
1. Ой, хээрийн түймэр, түүнээс сэргийлэх арга хэмжээ	2015.03.05	Нийгмийн ажилтан	Байгаль орчны байцаагч	
2.				
Олон нийтэд тайлагнах ажил				

Та нар гамшгаас хамгаалахтай холбоотой явууж буй үйл ажиллагаагаа үнэлэхээс гадна бүлгийн дотоод ажил, аливаа ажлыг зохион байгуулахад учирч буй бэрхшээл, сайжруулах арга зам, ахиц дэвшлээ мөн үнэлж, хамтдаа шийдэх хэрэгтэй.

Манай бүлэг хэрхэн ажиллаж байна вэ гэдгийг үнэлэхдээ сайн ба муу бүлэгт байх шинж чанаруудыг хэлэлцээд бид энэ хоёр ангиллын алинд нь орж байгаад дүгнэлт хийж болно.





## Сайн бүлэгт байдаг шинж чанарууд

- тэвчээртэй байх
- тэнцвэртэй байх
- бие биедээ итгэх
- хатуужилтай
- нэгдсэн санаатай
- нөхөрсөг
- ардчилсан удирдагчтай
- бүгдийг оролцуулдаг
- тэгш эрхтэй
- бие биедээ зааж сургадаг
- бусдынхаа чадвар, давуу талуудыг анзаардаг, мэдэрдэг байх
- бие биеэ хүндэлдэг байх
- шудрага бус явдлыг хараад тэвчдэггүй байх

## Муу бүлэгт байдаг шинж чанарууд

- хээл хахууль
- эрх мэдлээ ашигладаг
- нэг нэгнийхэ санал бодлыг сонсдоггүй
- бусдыг үйл ажиллагаандаа оролцуулдаггүй
- ялгаварлан гадуурхдаг
- зохион байгуулалт муу
- бие биедээ итгэдэггүй
- бие биеэ хүндэлдэггүй
- хүний эрхийг хүндэтгэдэггүй

Бүлгийнхээ давуу болон дутагдалтай талаа олж харах, цаашид үйл ажиллагаагаа сайжруулах ямар арга зам байгааг хамтдаа хэлэлцэж тогтоохдоо Олон улсад мөрдөгддөг “Н” үнэлгээний аргыг хэрэглээд үзээрэй.

## 1-р алхам. Ярилцах Бүлгийн гишүүд хамтдаа

- Бидний сайн чанарууд юу вэ?
- Муу болон дутагдалтай чанарууд юу вэ?
- Цаашид үйл ажиллагаагаа сайжруулахад ямар арга, зааварчилгаа хэрэглэх вэ? гэсэн асуултын дагуу ярилцана.

## 2-р алхам. Үнэлэх

Самбарын том цаасанд тааруулан “Н” үсэг бичнэ. Бичсэнийхээ дараа “Н” үсэгнийхээ дээд хэсэгт бүлгийн нэр, он, сар, өдөр. үнэлгээнд оролцсон хүүхдүүдийн товч мэдээллийг бичнэ.

“Н” үсэгнийхээ аль нэг талд 😊 инээж буй тэмдэг зурж бүлгийн сайн чанар, давуу талыг эсвэл явуулсан үйл ажиллагааныхаа ололттой талыг жагсаан бичнэ.

Харин “Н” үсэгнийхээ нөгөө талд 😞 уравгар царайтай тэмдгийн дор муу чанарууд болон сул талыг эсвэл явуулсан үйл ажиллагааныхаа дутагдалтай талыг жагсаан бичнэ.

Н” үсэгнийхээ доод хэсэгт (!) тэмдгийн дор давуу талуудаа улам илүү сайжруулах, дутагдалтай талаа хэрхэн засч сайжруулах санаануудаа жагсаан бичнэ.



## Хяналт, үнэлгээ хийхдээ анхаарах асуудал:



Өсвөрийн аврагчдаа та нар хяналт, үнэлгээг хийхдээ аливаа муу зүйлд буруутныг хайх биш, цаашид явал сайн болох талаар хамт олноороо хэлэлцэж, гарах гарцыг олж харах зорилгоор дүгнэж хэлэлцээрэй.

Бүлгийн зорилго, зорилттой уялдуулан аливаа үйл ажиллагаанд сайн болон муу гэсэн үнэлгээ өгөх хэрэгтэйг анхаарах. Учир нь заримдаа сайн гэж байгаа зүйл буруу болох муу гэж үзсэн зүйл зөв зүйтэй болох тохиолдол гардаг.

## 5. Бүлгийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах нь:

Бүлгээс явуулж байгаа ажлынхаа талаар олон нийтэд /найз нөхөд, гэр бүлийхэн/ байнга мэдээлэл, сурталчилгаа хүргэх, олон нийтийг энэхүү үйл ажиллагаандаа татан оролцуулах нь хамгийн чухал зүйл юм.

### Бүлгийнхээ ажлыг хэрхэн танилцуулах вэ?

Бүлэг нь ажлаа улирал тутамд сургууль, эцэг эх, орон нутгийн удирдлага, олон нийтэд танилцуулах хэрэгтэй.

Нэг улирлын хугацаанд бүлгийн гишүүд хэдэн ажил төлөвлөж, ямар шинэ мэдлэг, чадварыг эзэмшсэн тухайгаа нийтэд танилцуулж болно.

Танилцуулахдаа дараах зүйлийг харуулж болно:

- Би юу сурсан бэ? Шинэ мэдлэг, аюулгүй байдлын зөвлөмж гэх мэт
- Би юу хийсэн бэ? Сургуулийн галын аюулгүйн гарцын бүдүүвч зураг гаргасан гэх мэт
- Ямар ажил хамгийн их таалагдсан бэ? Яагаад?
- Надад болон манай гэр бүл, миний найзад ямар мэдлэг, чадвар хамгийн их тус болж чадах вэ? Яагаад?

Танилцуулгаа бусад хүмүүсийн анхаарал татахуйц арга хэлбэр (фото зураг, видео бичлэг, гар зураг гэх мэт)-ээр хүргэхийг хичээгээрэй.

Олон нийтэд үйл ажиллагаагаа сонирхолтой байдлаар танилцуулах маш олон арга байдаг. Үүнд:

### - Мэдээллийн самбар

Өөрсдийн зорилго, үйл ажиллагаа, төлөвлөгөө, үр дүнгээ мэдээллийн самбараар дамжуулан сургуулийн хамт олон, орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч, сурталчилгаа хийх

### - Хэвлэл мэдээлэл

Орон нутгийн радио, телевизээр гишүүд болон бусад сурагчид, багш нар эцэг, эхчүүд, орон нутгийн иргэдийн хийсэн санаачилсан сайн санаа, бүтээлч ажил, амжилт, сайн туршлагыг үзүүлсэн богино хэмжээний нэвтрүүлэг хийж цацах болон сонин, сэтгүүлд нийтлүүлж болно. Мөн өөрсдөө бүлгийн сонинг сар, улирал тутам эрхлэн гаргаж байх боломжтой.





#### - Үзэсгэлэн

Үзэсгэлэн нь хийсэн бүтээсэн ажлуудаа бусдад хүргэх хамгийн үр дүнтэй арга юм. Тиймээс хэрэгжүүлсэн ажил бүрийнхээ цуглуулсан мэдээ, хийсэн зурагт хуудас, фото зураг зэргийг фэйсбүүкдээ байрлуулах уриа болон бусад материалыг цэгцтэй хадгалж байвал дараа нь үзэсгэлэн гаргахад хэрэг болдог.

Жилийн турш хийсэн ажлуудаа зурагт хуудас, гэрэл зургаар харуулах хэрэгтэй. Мөн хийсэн судалгааны үр дүн, мэдээ баримтыг бас харуулж болно. Үзэсгэлэнг яаж сонирхолтой үр дүнтэй байдлаар зохион байгуулахаа гишүүд сайн бодож төлөвлөх хэрэгтэй. Үзэсгэлэнгийн үеэр хамтарч ажилласан хүмүүсээ урьж (төрийн холбогдох байгууллагын мэргэжилтнүүд, багш нар, олон нийтийн төлөөлөгчид) оролцуулбал тухайн арга хэмжээний ач холбогдлыг олон нийтэд ойлгуулж, нэр хүндийг нь дээшлүүлж өгөх сайн талтай.

#### - Нээлттэй өдөрлөг

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой тэмдэглэлт өдрүүдээр өөрсдөө тухайн сэдэвтэй холбоотой танилцуулга бэлтгэн үзүүлэх, жүжигчилсэн тоглолт бэлтгэх, мэргэжлийн хүмүүсийг урьж лекц сонсох зэргээр тухайн өдрийг олон нийтэд сурталчлах зорилгоор нээлттэй өдөрлөг хийж болно.

#### - Олон нийтийн сүлжээ

Интернет, мэдээллийн технологи хөгжсөн өнөө үед олон нийтийн сүлжээ болох Facebook, Twitter, You Tube зэрэг олон нийтийн сүлжээг ашиглан мэдээлэл, сурталчилгааг өргөн хүрээтэй хийх боломжтой.

#### - Тэмдэглэлт өдөр

Гамшгаас хамгаалах талаарх үндэсний болон олон улсын тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэж хэвших. Ийм өдрүүд нь ихэвчлэн жил бүр тодорхой нэг сэдвээр зохион байгуулагддаг тул тэрхүү сэдвийн хүрээнд орон нутагтаа сургалт явуулах, төрөл бүрийн хөгжөөнт тэмцээн зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэргээр олон хүнийг хамруулан тэмдэглэж болно.

#### **6. Бүлгийн үйл ажиллагаанд шаардлагатай, нөөц, чадавхыг бий болгох нь:**

Бүлэг үйл ажиллагаагаа амжилттай явуулахад хүний, санхүүгийн болон техник хэрэгслийн нөөц зайлшгүй шаардлагатай.

#### **Хүний нөөц**

Бүлгийн гол хүний нөөц бол хүүхдүүд та нар юм. Үүнээс гадна багш, сургуулийн удирдлага, эцэг эх, орон нутгийн иргэд, мэргэжлийн хүмүүсийг өөрсдийн үйл ажиллагаандаа татан оролцуулах замаар хүний нөөцөө нэмэгдүүлж болно.

Багш нарыг оролцуулах: багш нарыг шинэ мэдлэг, мэдээлэл өгөх, уралдаан тэмцээнд шүүгчээр ажиллуулах, ажил мэргэжлээс нь шалтгаалаад аливаа үйл ажиллагааныхаа хамтрагч болгох хүсэлт тавьж тэдэнд өөрсдийгөө ойлгуулах, дэмжлэг авах нь их ач холбогдолтой.





**Сургуулийн удирдлагуудыг оролцуулах:** бүлгийнхээ үйл ажиллагааны талаар сургуулийн удирдлагуудад мэдээлэл тогтмол хүргэж байх хэрэгтэй. Мөн тэднийг тусгай ёслол, арга хэмжээндээ урьж оролцуулж болно.

**Эцэг, эхийг оролцуулах:** Өөрсдийнхөө үйл ажиллагааны талаар эцэг, эхчүүдэд зөв мэдээлэл өгөх нь хамгийн чухал. Бүлгийн үйл ажиллагаа нь хүүхдийг хөгжүүлж, сайн үйлс хийх, нийгмийн хариуцлагад суралцах, хичээлээс гадуур бусад мэдлэг, чадварыг олж авахад нь тусалдаг гэдгийг аав, ээждээ ойлгуулах хэрэгтэй. Эцэг эхчүүдийг ажил мэргэжилтэй нь холбоотой зарим нэг арга хэмжээний үеэр шүүгч, зөвлөгч, хамтран зохион байгуулагчаар ажиллуулж болно.

**Орон нутгийн иргэдийг оролцуулах:** Орон нутагтаа байгаа мэргэжлийн байгууллагын ажилтан, туршлагатай хүмүүсийг өөрийн үйл ажиллагаандаа татан оролцуулах нь ажил үр дүнтэй болохын зэрэгцээ тухайн чиглэлээр өөрсдийгөө хөгжүүлж, мэдлэг, чадвараа сайжруулах ач холбогдолтой.

### Хүний нөөц бүрдүүлэхдээ анхаарах асуудал

*Бүлгийнхээ явуулах үйл ажиллагаатай уялдуулаад хамтран ажиллах байгууллага, хүмүүсээ сонгоорой. Хүмүүсийг бүлгийн үйл ажиллагаандаа татан оролцуулахын тулд тэдний санал, зөвлөгөөг асууж байх нь их ач тустай. Бүлэгт анх элсэж байгаа хүүхдийн эцэг эхэд бүлгийнхээ үйл ажиллагаа, зорилго чиглэл болон хүүхэд хэр их хугацааг энэ бүлгийн ажилд зарцуулах талаар мэдэгдсэн байвал зохино.*



### Санхүүгийн нөөц

Бүлэг тогтмол үйл ажиллагаагаа явуулахад тодорхой хэмжээний зардал гардаг. Иймээс бүлэг нь өөрийн гэсэн мөнгөн хөрөнгөтэй байх хэрэгтэй. Санхүүгийн нөөц бүрдүүлэхдээ дараах аргаас ашиглаж болно. Үүнд:

**Гишүүний татвар:** бүлэг нь тодорхой хэмжээний гишүүнчлэлийн татвар тогтоож зарим нэгэн үйл ажиллагааны зардлаа олж болно. Энэ аргын нэг сайн тал нь гишүүнчлэлийн татвар төлсөн гишүүд түүнийгээ юунд хэрхэн, үр дүнтэй зарцуулахад анхаардаг.

**Төсөл боловсруулах:** бүлэг өөрийн зорилгодоо нийцүүлсэн жижиг төслийг боловсруулж хандивлагч, дэмжигчид болон бизнесийн байгууллагад хандаж санхүүжилт авч болно. Хэрвээ төсөл авч хэрэгжүүлсэн бол хэрэгжилтийн явцыг байнга мэдээлж, хяналт үнэлгээ хийж, цаг хугацаанд нь тайлангаа өгч байх хэрэгтэй. Төсөл боловсруулах зааврыг 3-р хавсралтаас харна уу.

**Ивээн тэтгэгч, хандивлагч хайх:** тухайн орон нутагт бүлгийн үйл ажиллагаанд санхүүгийн болон өөр дэмжлэг үзүүлэх байгууллага, хувь хүн байдаг ба тэдгээрт явуулах гэж буй үйл ажиллагааныхаа зорилгыг танилцуулж эд материалын болон өөр ямар нэг хэлбэрээр хандив тусламж авч болно

**Хөрөнгө босгох:** хөрөнгө босгож болох янз бүрийн санааг эрж олон түүнийг бүлгийн хүүхдүүдийн нөөц бололцоо, авьяас чадвар (урлагийн



тоглолт, гар урлал, хоёрдогч түүхий эд гэх мэт)-ыг ашиглан хэрэгжүүлж болох юм.

### Санхүүгийн нөөц бүрдүүлэхдээ анхаарах асуудал

*Мөнгө төгрөг, техник тоног төхөөрөмж бэлэн байснаар үйл ажиллагаа дандаа сайн явагдах, эсвэл байхгүй байснаар ажил муу явагдана гэж үзэж болохгүй. Хүн санаачлагатай байснаар дутагдаж байгаа зүйлсийг олох нөөц боломж, гарцыг ямагт олдог гэдгийг санах хэрэгтэй.*



### Техник, хэрэгслийн нөөц

Бүлэгт явуулж буй үйл ажиллагаа бүрийнхээ онцлогоос шалтгаалж янз бүрийн өрөө байр, техник хэрэгсэл зайлшгүй хэрэгтэй болно. Иймд хамгийн гол нь хийх ажлынхаа төлөвлөгөөг урьдчилан үе шат бүрээр нь сайтар төлөвлөж гаргасныхаа дараа холбогдох хүмүүст нь танилцуулж хамтарч ажиллах санал тавина. Зарим сургуулийн удирдлага сурагчдын бүлгээ дэмжиж анхнаас нь тусгай өрөө гаргаж өгөх тохиолдол байдаг. Мөн үйл ажиллагаа нь амжилттай явагдаж тодорхой үр дүн гарч түүнийгээ сургуулийн удирдлага болон бусад хүмүүст хүргэж чадсанаар байрны асуудлаа шийдэж болдог.

### Бүлгийн үйл ажиллагаанд

- эмийн сан
- анхан шатны тусламжийн багц
- хүний биеийн макет
- хүрз, хувин, бусад багажууд
- гарын авлага, танилцуулга
- орон нутгийн газрын зураг
- компьютер, мэдээллийн хэрэгсэл, зургийн аппарат, зурагт, VCD, CD тоглуулагч (сургуулийнхийг ашиглаж болно)
- мэдээллийн самбар
- бичгийн хэрэгсэл гэх мэт.

Энэ тал дээр сургуулийн удирдлагад хандаж дэмжлэг авах нь зүйтэй. Мөн гамшгаас хамгаалах болон хүүхдийн оролцоог дэмждэг хандивлагч байгууллагуудад жижиг төсөл бичин өөрсдийн гэсэн тоног төхөөрөмжтэй болж болох юм.

Бусад шаардлагатай зүйлсийг өөрсдөө гарын доорх материал ашиглан томчуудын тусламжтайгаар хийж болно. Мөн сайн санаат хүмүүсийн хандивласан техник хэрэгсэл, ном гарын авлагаар нөөц бүрдүүлэх боломжтой.

### Анхаарах асуудал

*Ямар ч тохиолдолд бүлгийн үйл ажиллагаа явуулж буй өрөө танхим нь бусад хүмүүст аль болох нээлттэй байх явдал хамгийн чухал гэдгийг байнга санаарай.*





### 1.3. БҮЛГЭЭ ХЭРХЭН ХҮЧИРХЭГ БАЙЛГАЖ, ХӨГЖҮҮЛЭХ ВЭ?

Бүлэг өөрийн үүсэл хөгжил, түүх, гишүүдийн бүтэц хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар болон өөрсдийн ололт амжилт, алдаа дутагдлыг дүгнэж цэгнэж байх нь үйл ажиллагаагаа доголдолгүй явуулах үндэс болдог.

**Бүлгийнхээ түүхийг баримтжуулах ба гишүүдээ идэвхтэй ажиллуулах, урам зориг өгөх**

#### а. Бүлгийн түүхээ бичихдээ:

Он цагийн хэлхээг гаргах. Гишүүдээс бүлэг хэзээ яагаад байгуулагдах болсон, хэн санаачилсан, яагаад үүнийг санаачлах болсон талаар асууж ярилцуулан тэмдэглэнэ.

Бүлгийн гишүүдийн тоо, гишүүн шинээр элсэх, гарах шалтгааныг шинжилж бүртгэх. Гишүүд яагаад бүлэгт элсдэг, яагаад гишүүд бүлгээсээ гардаг, ямар гишүүд нь гарч, ямар гишүүд нь үлддэг, ямар гишүүнийг бүлгээс гарахад бүлгийн үйл ажиллагаа доголдож байсан талаар харилцан ярилцаж дүгнэлт гаргана. Энэ нь цаашид гишүүдийн талаар анхаарах асуудлыг тодорхой болгож, гишүүд солигдсон ч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах аргыг төлөвлөхөд шаардлагатай мэдээлэл өгнө. Мөн гишүүд урьд нь байсан гишүүд одоо бүлгийн үйл ажиллагаатай холбоотой байдаг уу, тэд өөр бүлэгт элссэн үү эсвэл шинээр бүлэг байгуулсан уу гэдгийг мөн судлаж мэдэх хэрэгтэй.


Бүлгийнхээ ололт амжилт, алдаа дутагдлыг бүртгэх. Бүлэг байгуулагдсан цагаас өнөөг хүртэлх хугацаанд ямар ямар чухал үйл явдал болсон, амжилттай хэрэгжсэн үйл ажиллагаа, санаачлагууд, гаргасан амжилтууд болон бүлэг дотор гарсан хүндрэл бэрхшээл, түүнийг хэрхэн шийдсэн туршлага, үйл ажиллагаандаа гаргасан алдаа, дутагдлын талаар гишүүд хамтдаа ярилцаж тодорхойлно. Энэ мэдээллийг цаашид бүлгээ хэрхэн тогтвортой авч явах төлөвлөгөө гаргахдаа ашиглана.

#### б. Хүүхдүүдээ та нар аливаа ажлыг зохион байгуулахдаа гишүүдээ идэвхтэй ажиллуулах, урам зориг өгөхийн тулд:

- Үйл ажиллагаагаа хөгжилтэй байдлаар явуулах. Бүлгийн гишүүн болон бусад оролцогчид явуулж буй үйл ажиллагаанаас баяр цэнгэл, хөгжил хөөрийг мэдэрдэг байх нь хамгийн чухал. Өөрөөр хэлбэл хүүхдүүдийн сонирхол татахуйц, идэвхтэй оролцохуйц байдлаар аливаа ажлыг зохион байгуулах
- Гишүүддээ итгэл үнэмшил төрүүлэх. Тухайн ажлыг хийх нь өөрийн болон бусдын сайн сайхны төлөө бөгөөд хамтарч ажиллаж байж тодорхой үр дүнд хүрч чадна гэдгийг гишүүд болон бусдад ойлгуулах итгүүлэх
- Ажлын үр дүнгээ тайлагнах. Зохион байгуулсан ажлынхаа үр дүнг байнга сонирхолтой байдлаар нийтэд мэдээлж байх, амжилттай, идэвхтэй сайн оролцогчдод тусгайлан баяр хүргэж байгаагаа нийтэд ил тод илэрхийлэх.



Child  
Баг.



Улиртай сумын  
Улиралын  
хуанли  
ХАВАР  
ЗУН  
аюултай  
цас.  
БОРОО  
Цахилгаан  
- цасны  
тувшин  
- 2 огцом  
ихса







## СЭДЭВ 1: ГАМШГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ



### Уншаад ярилцаарай

#### Аюул гэж юу вэ?

Аюул, осол гэдэг нь хүмүүс, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой үзэгдэл ба үйл явц юм.

Хүүхдүүд та нар ямар ямар аюул, ослыг мэдэх вэ? Жишээ гарган ярилцаарай.

Байгалийн аюулт үзэгдэл, хүний үйл ажиллагаатай осол нь зарим нөхцөлд гамшиг болж хувирдаг. Та нар тэр нөхцлийг нь мэдэх үү?

#### Гамшиг гэж юу вэ?

Аюул нь дараах гурван нөхцөл нэгэн зэрэг бүрдсэн үед гамшиг болно.

- аюулт үзэгдэл, осол тохиолдсон
- аюулт үзэгдэл, осолд хүн, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин их хэмжээгээр өртөж хохирсон,
- хүмүүсийн хэвийн амьдралын нөхцөл алдагдсан
- өөрийн хүчээр даван туулах боломжгүй болсон



### Хамтдаа хийцгээе

Орон нутгийнхаа гамшгийн цаг хугацааны түүхэн зураглалыг хамтдаа гаргаж танилцуулга бэлтгэн бусад хүмүүст хүргэж болно.

Хүүхдүүдээ цаг хугацааны түүхэн зураглалыг хийхдээ дараах зааварчилгааг ашиглаарай.

Цаг хугацааны түүхэн зураглал хийх зааварчилгаа

Зорилго: Орон нутагтаа урьд өмнө болж байсан гамшгуудыг эргэн сануулах, эдгээрийн давтамж нь хэр ойртож байгааг тодорхойлох

Хийх дараалал: Бүлгийн гишүүд урьд жилүүдэд тохиолдож байсан гамшгийн талаар мэдээлэл цуглуулах. Ингэхдээ аль болох олон жилийн өмнөөс эхлэх нь сайн шүү.

Тухайн гамшиг хэзээ, хаана, болсныг тэмдэглэнэ тэгэхдээ яг хэдэн сарын хэдэнд болсон гэдгийг тодорхой бичих шаардлагагүй.

Цуглуулсан мэдээллээ цаг хугацааны хүснэгтэд оруулна.

Юунд ашиглах вэ? орон нутагт тохиолдсон гамшгийн талаарх мэдээлэлтэй болно. Энэхүү мэдээллээ бусадтай хуваалцана.





## Үүнийг мэдэх үү

Дэлхий дээр 40 гаруй төрлийн гамшиг тохиолдож эдгээрт жилд дунджаар 200 000 000 хүн нэрвэгдэж, 100 000 гаруй хүн амь насаа алддаг байна. Монгол оронд 10 гаруй төрлийн гамшигт жилд дунджаар 200 хүн амь насаа алдаж байна.




## СЭДЭВ 2. ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИО

### Уншаад ярилцаарай



“Гамшигийн аюулын тухай зарлан мэдээлэл” гэж хүн амд учир ч болзошгүй гамшигийн аюулын тухай дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг төвлөрсөн мэдээллийн хэрэгсэл, тусгай хэрэглээний холбоо, орон нутгийн болон олон нийтийн радио, телевиз, мэдээлэл, харилцаа холбооны бүх төрлийн хэрэгсэлээр нэн даруй хүргэхийг хэлнэ.

Зарлан мэдээлэл нь дараах 2 төрөлтэй байна.



	Сэрэмжлүүлэх мэдээ	Гамшигийн аюулын дохио
Хүргэх хэлбэр, утга	“Цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ” гэсэн толгойтой “ХАРАНГА” дохиотойгоор мэдээллийн хэрэгслээр дамжуулна.	“Анхаараарай, анхаараарай! Онцгой байдлын албанаас (Засаг даргын тамгын газраас) ярьж байна.”/гамшигийн аюулын нэр...../ аюулын түгшүүр” гэж зарлана. Жишээ нь: түймрийн аюулын түгшүүр гэх мэт
Ашиглах техник хэрэгсэл, сүлжээ	Төвлөрсөн зарлан мэдээллийн хэрэгсэл Радио, телевиз Телефон утас Гар утас Мэдээллийн сайт	Төвлөрсөн зарлан мэдээллийн хэрэгсэл Байгууллагын дотоод холбооны төхөөрөмж, Мэдээллийн дэлгэц, Төрөл бүрийн дохиоллын хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, Чанга яригч; Бие холбоочин





### Хамтдаа хийцгээе

Жил бүрийн 3 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагийн 16.00 цагт улс орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дадлага, сургалт хийж, бэлэн байдлыг хангах ажил явагддаг тул бүлгийн гишүүд энэ өдрийг төлөвлөгөөндөө тусгаж дадлага, сургалт хийгээрэй. Ингэхдээ бүлэгийн гишүүд хоёр багт хуваагдан нэг баг нь амьдарч буй орон нутгийнхаа зарлан мэдээлэл дамжуулах хэрэгсэлтэй харин нөгөө баг нь сургуулийнхаа зарлан мэдээлэл дамжуулах хэрэгсэл, мэдээлэл дамжуулах төлөвлөгөөтэй танилцаж найз нөхөд, багш ажилчид, гэр бүлийнхэндээ зориулан танилцуулга бэлтгэн зааж сургах ажлыг хийж болох юм.



### Үүнийг мэдэх үү

Тилли Смит гэдэг 10 настай Англи охин Тайландад аав, ээжтэйгээ амарч явахдаа 2004 онд Энэтхэгийн далайд болсон цунамийн үеэр далайн эрэг дээр амарч байсан 100 гаруй жуулчдын амь насыг аварчээ. Тилли Смит Тайландад жуулчлахаас 14 хоногийн өмнө газарзүйн хичээлээрээ цунами болохын өмнө далайн мандал дээр ажиглагдах шинж тэмдгийг заалгасан байна. Энэхүү хичээлээс олж авсан мэдлэгээ ашиглан далайн эрэг дээр амарч байгаа гэр бүлийнхэн, бусад амрагчдад цунами болох гэж байгаа тухай сэрэмжлүүлэг хүргэж богино хугацаанд хүмүүсийг аюултай газраас холдуулж олон хүний амь насыг аварчээ.



Түүний энэхүү баатарлаг үйлсийнх нь төлөө Нэгдсэн Үндэстний байгууллага онцгойлон баяр хүргэж, гамшгаас хамгаалах боловсролын ач тусыг дэлхий дахинд тодорхой харуулсан үйлдэл болсон гэж үзжээ.

## СЭДЭВ 3. ГАЛ ТҮЙМЭР ХЭРХЭН ГАРДАГ ВЭ?



### Уншаад ярилцаарай

#### Гал яагаад гардаг вэ?

Гал бол түлш, хүчилтөрөгчийн харилцан үйлчлэлээр бий болон гэрэл гаргаж, дулаан ялгаруулдаг химийн үзэгдэл юм. Гадаад хүчин зүйл болох дулаан нь харилцан үйлчлэл эхлэхэд нөлөөлдөг. Эдгээр 3 хүчин зүйлийг ГАЛЫН ГУРВАЛЖИН гэх бөгөөд аль нэг нь байхгүй тохиолдолд гал асахгүй.





Хүчилтөрөгч



Дулаан

Түлш

Хүүхдүүдээ гал түймрээс урдчилан сэргийлэх, гарсан галыг унтраахын тулд энэ 3 эх үүсвэрийн аль нэгийг байхгүй болгох шаардлагатай.

Аль эх үүсвэрийг таслан зогсооход хялбар гэж бодож байна. Яагаад гэдгээ ярилцаарай.

Дулааны эх үүсвэр нь байгалийн нарны гэрэл, аянга, цахилгаан байдаг бол хүний хүчин зүйлийн тусламжтайгаар шүдэнз, түүдэг гал зэрэг нь дулаан үүсгэнэ. Хүчилтөрөгч бол агаарын найрлаганд оролцдог. Түлш бол галд шатаж болох бүх зүйл юм.

Хүүхдүүдээ та нарт гал түймэр яагаад аюултай вэ гэдгийг хэлж өгье.

**Гал түймэр бол маш хурдан болдог:** гал түймрийн үед ямар нэг эд зүйлээ авах, утсаар дуудлага хийх ямар ч боломжгүй. Ердөө хоёр минутад гал түймэр хүнийг үхэлд хүргэнэ. Тав хүрэхгүй минутийн дотор гэр, байшин галын дөлөнд шатаж дуусна.

**Гал түймэр бол халуун:** гал түймрийн үед үүсэх халуун болон утаа нь галын дөлөөс хэд дахин илүү аюултай. Халуун агаараар амьсгалахад таны уушиг түлэгдэнэ. Мөн гал түймрийн үед үүсэх хортой хий нь хүнийг мансууруулж зугтах чадваргүй болгоно.

**Гал түймэр бол харанхуй:** гал түймрийн үед ялгарсан утаа нь гадагш гарах замаа олж харахад төвөгтэй болно.

**Гал түймэр бол үхэлд хүргэнэ:** гал түймрийн үед бидний амьсгалдаг агаар дахь хүчилтөрөгчийн хэмжээ багасч, оронд нь хүн амьсгалсан тохиолдолд үхэлд хүргэх утаа, хортой хий ялгарна.

Хамтдаа хийцгээе



### “Гал” тоглоом

Найз, нөхөддөө гал түймэр яагаад гардаг талаар зааж сурган, хамтдаа энэхүү тоглоомыг тоглоорой.

**Оролцогчид: 15-30 хүүхэд**

**Хэрэглэгдэх зүйл:** оролцогч хүүхдийн тоогоор цэнхэр, ногоон, улбар шар өнгийн цаасаар хийсэн карт

- Оролцогч хүүхдүүдэд дээрх өнгийн картуудаа тарааж өгнө. Цэнхэр





өнгө нь агаар, ногоон өнгө нь түлш, улбар шар өнгө нь дулааныг тус тус илэрхийлнэ.

- Бүлгийн багш эсвэл аль нэг хүүхэд оролцогчдыг удирдаж “түлш, агаар, гал, дулаан” гэсэн 4 үгийг ээлжлэн хэлнэ. Бусад хүүхдүүд өөрсдийн өнгөө цээжлэн удирдагчийн хэлэх үгийг анхааралтай сонсож үйлдэл гүйцэтгэнэ.
- Удирдагч “Гал” гэж хэлбэл түлш, агаар, дулаан болсон хүүхдүүд нэгдэж гурав, гурваараа гал болон зогсоно.
- Удирдагч “Дулаан” гэж хэлбэл дулаан болсон 3 хүүхэд нийлж зогсоно. Харин “агаар” гэвэл агаар болсон 3 хүүхэд, “Түлш” гэвэл түлш болсон 3 хүүхэд нийлж зогсоно
- Удирдагчийн хэлсэн үгнээс зөрүүлж нийлсэн хүүхэд болон сондгойрч хоцорсон хүүхдүүд тоглоомоос хасагдах хэлбэрээр тоглоно.



### Үүнийг мэдэх үү

#### Аль ч галыг унтраахад ус ашиглаж болох уу?

Хүүхдүүдээ тостой гал руу ус цацахад гал улам дүрэлздэг тул хэрвээ тостой тогоонд гал гарвал нэн даруй тогооны тагийг тавьж, галаа унтраах хэрэгтэй шүү.


## СЭДЭВ 4. АХУЙН ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА, ТЭМДЭГ ТЭМДЭГЛЭГЭЭ



### Уншаад ярилцаарай

#### Ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга

Гал түймэр нь бусад гамшгуудтай харьцуулахад урьдчилан сэргийлэх боломжтой юм. Гал түймрээс урдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга зам бол галыг болгоомжтой ашиглах явдал юм.





**Гал түймэр гаргахгүй байхын тулд дараах зүйлийг анхаараарай хүүхдүүдээ.**

<p>Шүдэнз болон гал асаах хэрэгслийг хүүхдийн гар хүрэхгүй өндөр газар хадгалах</p>	<p>Тамхи татдаг хүмүүст тамхиа бүрэн гүйцэд унтраахыг сануулах</p>	<p>Гэрийнхээ зуух, цахилгаан зуух, хийн зуух зэргийн аюулгүй найдвартай ажиллаж байгаа эсэхийг шалгах, зуухны ойр орчмыг цэвэр байлгах, элдэв шатамхай зүйлсийг хол байлгах</p>	<p>Тог тасарсан үед гар чийдэн ашиглах. Хэрэв лаа асаавал асаж буй лааг хараа хяналтгүй хоромхон зуур ч орхиж явж болохгүй</p>
			
<p>Цахилгаан хэрэгсэл залгаатай орхиж огт болохгүй. Хэрэглэж дуусаад цахилгаан хэрэгслээ салгаж хэвших</p>	<p>Уртастагч залгуур хэрэглэх, залгуурын ачаалал хэтрүүлэхээс зайлсхийх, цахилгаан хэрэгслийг баталгаатай газраас худалдаж авах</p>	<p>Бага насны хүүхдийг харах хүнгүйгээр гэрт үлдээж болохгүй</p>	<p>Шатамхай эд зүйлийг гал гаргагч зүйлээс хол газар хадгалах, хэрэглэсэн химийн бодисын үлдэгдлийг тагтай саванд хийж хадгалах</p>
			

**Гал түймрийн аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээ**

Гал түймрийн аюулд өртөж амь насаа алдахээс сэргийлэхийн тулд гал түймрийн үед хэрхэн ажиллах төлөвлөгөө гарган, энэ төлөвлөгөөний дагуу дадлагыг гэр бүлээрээ, сургуулиараа жилд 2 удаа хийж хэвшсэн байх нь чухал шүү.

Гал түймрийн үед гэр, сургуулиасаа аюулгүй гарахын тулд галын аюулын үеийн нүүлгэн шилжүүлэлтийн тэмдэг, тэмдэглэгээг мэддэг байх ёстой. Нүүлгэн шилжүүлэх замыг дараах тэмдэглэгээг ашиглан төлөвлөнө.



## Нүүлгэн шилжүүлэх замын тэмдэг, тэмдэглэгээ

		Нүүлгэн шилжүүлэлтийн гарцын чиглэл
		Шатаар доош буух нүүлгэн шилжүүлэлтийн гарц
		Шатаар дээш гарах нүүлгэн шилжүүлэлтийн гарц
  		<b>Нүүлгэн шилжүүлэлтийн чиглэл</b> Нүүлгэн шилжүүлэлтийн үндсэн гарц руу гарах хөдөлгөөний чиглэлийг заана Нүүлгэн шилжүүлэлтийн нөөц гарц руу гарах хөдөлгөөний чиглэлийг заана

Сургууль гэрийнхээ бүдүүвч зургийг зурж, гал түймрийн аюулын үед гарах гарцыг тэмдэглэж, зургийн дагуу өөрсдийн биеэр алхаж, төлөвлөсөн гарцуудаа богино хугацаанд олж барилгаас аюулгүй гарах дадлага хийх хэрэгтэй. Гал түймрийн гарцаар дан ганц хаалгаа ашиглах биш шаардлагатай тохиолдолд цонхыг ч мөн ашиглаж болно. Гарц болгон ашиглахаар төлөвлөсөн цонх хэвийн онгойж байгаа эсэхийг шалгаарай.



### Хамтдаа хийцгээе


Хүүхдүүдээ сургуулийнхаа барилгын бүдүүвч зурагт гал түймрийн үед сургууль дотор байгаа хүмүүсийг хэрхэн аюулгүй нүүлгэн шилжүүлэлт хийх төлөвлөгөө гарган, найз нөхөддөө танилцуулж, энэ дагуугаа дадлага хийгээрээ.

Мэргэжлийн хүний заавар зөвөлгөөг авах хэрэгтэй шүү.



### Үүнийг мэдэх үү

Манай улсад жилд дунджаар 2500 ахуйн гал, түймэр гарч үүний улмаас ойролцоогоор 60 хүн амь насаа алдаж байна. Хүүхдүүдээ гал, түймрийн гаралт байнга нэмэгдэж байгаа тул гал, түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах хэрэгтэй юм байна шүү.





## СЭДЭВ 5. ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМЭР, ТҮҮНЭЭС СЭРГИЙЛЭХ АРГА

### Уншаад ярилцаарай

Ой хөвчид мод, ургамал хяналтгүйгээр үргэлжлэн шатахыг ойн түймэр гэнэ.

Тал хээрт хүний хяналтаас гадуур тархан шатаж байгаа галыг хээрийн түймэр гэнэ.

### Ой, хээрийн түймэр гарах шалтгаан

Ой, хээрд янз бүрийн шатах зүйл (өвс, мод, бут) болон хүчилтөрөгч (агаар) хангалттай байдаг. Харин шатлагыг үүсгэдэг дулааны (галын) эх үүсвэр гаднаас орж ирнэ.

### Ой, хээрт галын 2 эх үүсвэр байна :

Байгалийн гэнэтийн үзэгдэл /Түймэр гарах шалтгааны 10%-ийг эзэлнэ/	Хүний санамсар, болгоомжгүй үйл ажиллагаа /Түймэр гарах шалтгааны 90%-ийг эзэлдэг/
Аянга, цахилгаан Хөрсөн доорх хүлэр өөрөө авалцах	Ил задгай асгасан цогтой үнс нурам Унтраалгүй хаясан тамхи, шүдэнз Зуухны яндангаас хаясан очтой хөө Оч баригчгүй яндантай трактор, машин, мотоцикль Хүүхэд галын аюултай зүйлээр тоглох Бүрэн унтраагүй болон ил задгай түлсэн гал Дохионы пуужин харвах Галт сумаар буудах

Ой, хээрийн түймэр ихэнхдээ хүний буруутай болон санамсаргүй үйлдлээс гардаг гэдэгтэй хүүхдүүдээ та нар санал нийлэх үү?

### Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх вэ?

- Цогтой үнс нурмаа битүү тагтай саванд хийх
- Тамхи, шүдэнзний галыг ил задгай хаяхгүй байх
- Гэр сууц, хашаа хорооныхоо гадуур түймрээс хамгаалах зурвас татах
- Хуурайшилт ихтэй хавар, намрын үед хээр, хөдөө, ой модонд ил задгай гал гаргахгүй байх





## Хамтдаа хийцгээе

Сургуулийнхаа Эко клуб, сумын ойн нөхөрлөл, бусад мэргэжлийн байгууллага, сайн дурынхантай хамтран хээр, хөдөө явахдаа гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх самбар байрлуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээ явуулаарай.

Ингэхдээ дараах уриа, сэрэмжлүүлгийг ашиглаж болно. Мөн хүүхдүүд та нар өөр олон төрлийн сэрэмжлүүлэх уриа үгийг зохион хэрэглээрэй.

- Ой модоо гал түймрээс хамгаалцгаая!
- Шүдэнз тамхины галыг бүрэн унтрааж, хаяарай!
- Үнс нурамныхаа цогийг бүрэн унтраагаарай!
- Таны техникийн яндангаас оч хаялахвий!
- Болгоомжил, санамсаргүй байдлаас гал алдуузай!
- Таны хөдөлмөрийн багаж, зэвсэг гал гаргахгүй гэдэгт найдаж байна!
- Бидний зуун жил ашиглах баялгыг гал түймэр ганцхан хоромд устгана!
- Зэрлэг амьтадаа гал түймрээс хамгаалцгаая!.


Ой хээрийн түймрээс сэргийлэх самбар хийх уралдааныг сургуулийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж, шалгарсан самбаруудын тухайн хүүхдийн нэрийн хамтаар хэвлэн байрлуулвал их сонирхолтой байхыг бодолцоорой.



## Үүнийг мэдэх үү

Хүүхдүүдээ та нар монгол орны ойн хэмжээ жил ирэх тутам буурч байгааг энэ зурагнаас харж болно. Тиймээс ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг орон нутагтаа зохион байгуулж эх орныхоо ойн нөөцийг хамгаалахад хувь нэмрээ оруулаарай.

Ойгоор бүрхэгдсэн талбайн өөрчлөлт - (6 жилд)







## СЭДЭВ 6. ХҮТЭЙ САЛХИ, ШУУРГАНААС ХАМГААЛАХ АРГА

Уншаад ярилцаарай



Байгалийн үзэгдэл болох салхийг хэрхэн үүсдэгийг хүүхдүүд та нар газарзүйн хичээлээрээ мэддэг болсон. Энэхүү мэдлэгээ эргэн санаарай. Салхи ямар үед аюултай болох вэ?

Хүчтэй салхи, шуурга гэж юуг хэлэх мөн түүний учруулах аюулын талаар хамтдаа мэдэж авцгаая. Учир нь хүчтэй салхи, шуурга нь олон гамшигт үзэгдлийг үүсгэдэг өдөөгч хүч болж байдаг.

### Хүчтэй салхи, шуурганы шинж чанар

<p><b>Хүчтэй салхи</b></p>	<p>салхины хурд 16 м/с түүнээс их, 3 цагаас дээш хугацаагаар үргэлжлэх агаарын урсгал</p>
<p><b>Хүчтэй цасан шуурга</b></p>	<p>салхины хурд 12 м/с ба түүнээс илүү алсын бараа 2000 м-ээс бага болж 3 цаг ба түүнээс дээш хугацаагаар цасаар шуурах цаг агаарын үзэгдэл</p>
<p><b>Хүчтэй шороон шуурга</b></p>	<p>16 м/с түүнээс дээш хүчтэй салхины улмаас элс, шороо их хэмжээгээр агаарт хөөрөн, үзэгдэх орчинг хязгаарлаж эрс муутгах агаар мандлын үзэгдэл</p>

Салхины хурд м/с	Нэршил	Салхины илрэх шинж ба учруулах аюул	Цаг агаарын мэдээгээр хүргэх хэлбэр
14 хүртэл	Зөөлөн	Навчис сэржигнэж, нарийхан мөчир туялзана. Өвсний толгой найгалзана. Туг, дарцаг дэвэлзэнэ. Цаас хийснэ. Шороо босно. Дээлийн хормой дэрвэнэ.	“Цэнхэр залаа” аятайгаар салхины хурдыг зааж хүргэнэ
15-29	Хүчтэй	Барилгын муудсан болон хөнгөн материалаар хийсэн дээвэр, тоосгон яндан нурна. Мод тахийж мөчир нь хугарна.	“Цаг агаарын аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ” гэсэн тайлбартайгаар хүчтэй салхины хурдыг зааж хүргэнэ
30-аас дээш	Аюултай	Мод, байшин, гэр, хашаа нурна. Хүн, жижиг мал ойчно. Гэр нурна. Тэнгэр харанхуйлна.	“Харанга” дохиотойгоор “Цаг агаарын нэн аюултай буюу гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ” гэсэн тайлбартайгаар хүчтэй салхины хурдыг зааж хүргэнэ



**Хүүхдүүдээ хүчтэй салхи, шуурганы аюул болох тухай цаг агаарын мэдээгээр зарласан тохиолдолд юу хийх вэ?**

- Цаг агаарын байдлын талаар мэдээлэл сайн ав
- Боломжтой бол гэрээсээ бүү гар
- Малаа хашаа, хороонд нь оруул
- Дулаахан хувцасла
- Түлээ, түлшээ нөөцөл

### Хүчтэй салхи, шуурга хүмүүс бидэнд ямар хохирол учруулах вэ?

Хүүхдүүд хүчтэй салхи, шуурганы үед төөрөх улмаар хөлдөх, осгох зэргээр амь насаа алдах аюул түгээмэл гардаг. Иймд гэр бүл, найз нөхөд эсвэл хэн нэгэн хүн хөлдсөн эсвэл осгосон үед хэрхэн тусламж үзүүлэх аргыг сурцгаая.

### Хөлдөлт ба осголтын үед үзүүлэх тусламж

#### Хөлдөлт

Хөлдөлт нь биеийн аль нэг хэсэгт удаан хугацаагаар хүйтэн үйлчилсэн үед тохиолдоно. Хүний биеийн гар, хөл, чих, хамрын үзүүр, хацар зэрэг захын эрхтнүүд амархан хөлдөнө.

#### Хөлдөлтийн зэрэг ба шинж тэмдэг



### Хөлдөлтөд хэрхэн анхан шатны тусламж үзүүлэх вэ?

#### 1. Нэрвэгдэгчийг дулаан байранд оруулж, хувцасыг нь тайлна.

- Түргэн тусламж дуудлага өгөх
- хөлдсөн үе мөчийг хуурай даавуугаар арчиж, бүлээн устай (32-34.5 хэм) саванд дүрнэ
- 10 минутын дараа усны дулааныг 40.5 хэмд хүргэнэ



#### 2. Арьсны мэдрэмж, цусны эргэлт сэргэсэн үед үе мөчийг хуурай болтол арчина

- 33 хувийн спиртийн уусмалаар арчиж, цэвэр боолт хийнэ
- дулаан хучиж, халуун цай уулгана.
- Нэрвэгдэгчийг дулаан байранд оруулж, тасалгааны хэмтэй усанд оруулж, усны хэмийг аажмаар 36°C хүртэл ихэсгэнэ.
- Биенд зөөлөн иллэг хийж, ухаан орохоор нь дулаан хучиж, халуун цай, шөл бага багаар өгнө.



## Осголт

Хүний бие бүхэлдээ даарснаас болж бүх бие нь хөшиж, улмаар муужран унана.

Хүмүүс хүйтэн сэрүүний улиралд хувцасаа тохируулж өмсөөгүйгээс осголт их тохиолддог.

## Осголтод анхан шатны хэрхэн тусламж үзүүлэх вэ?

- Нэрвэгдэгчийг дулаан байранд оруулж, тасалгааны хэмтэй усанд оруулж, усны хэмийг аажмаар 36°C хүртэл ихэсгэнэ.
- Биенд зөөлөн иллэг хийж, ухаан орохоор нь дулаан хучиж, халуун цай, шөл бага багаар өгнө.

## Хамтдаа хийцгээе



### “... ж болохгүй” тоглоом

Оролцогчид: 10-20 хүн

Хэрэглэгдэх зүйл: бөмбөг эсвэл зөөлөн зүйл

- Оролцогчид тойргоор зогсоно
- Зохицуулагч нэг оролцогч руу бөмбөг /зөөлөн зүйл шидэж “... ж болохгүй” гэсэн өгүүлбэр хэлнэ. Жишээ нь: “Цаг агаарын мэдээ сонсохгүй байж болохгүй”. гэх мэт
- Бүх оролцогч бөмбөгөө дамжуулан дээрхийн адил хүчтэй салхи, шуурганаас хамгаалах арга, хөлдөх, осгох аюултай холбоотой “... ж болохгүй” гэсэн төгсгөлтэй өгүүлбэрийг хэлж дуустал үргэлжилнэ.
- Хэрэв хэн нэг оролцогч зөв өгүүлбэрээ зохиож чадахгүй бол хасагдах зарчмаар тоглож ялагчаа тодруулна.

## Үүнийг мэдэх үү



### Хөлдөж, осгохгүйн тулд хэрхэн хувцаслах вэ?

Хүйтэнд маш зузаан хүнд хувцас өмсөхийн оронд сул чөлөөтэй, хөнгөн, дулаан хувцасыг олон давхарлаж өмсөх хэрэгтэй. Учир нь давхар хувцаснуудын завсрын агаар дулааныг сайн хадгалдаг. Зузаан хувцастай хөлрөөд, дараа нь хөлсөндөө жиндэхгүйн тулд халууцвал гадуурх хувцасаа тайлна. Жиндвэл буцааж өмсөж болно. Биеийн дулаан алдагдлын тал нь толгойгоор алдагддаг тул малгай өмс. Бугуйгаараа бариу 2 хуруутай бээлий нь таван хуруутай бээлийнээс дулаан байдгийг санаарай.



## СЭДЭВ 7. АЯНГА, ЦАХИЛГААНААС ХАМГААЛАХ АРГА

### Уншаад ярилцаарай

Аянга гэдэг нь цэнэгжсэн үүлнүүдийн хооронд эсвэл үүл, газар хоёрын хооронд явагдах цахилгааны ниргэлт юм.

Бүх аянганаас үүсэх цахилгаан нь хүний амь насанд аюул учруулдаг.

### Ямар нөхцөл байдал бий болоход хүмүүс аянганд нэрвэгддэг вэ?



Аянга цахилгаан шууд буух үед



Аянганы цахилгаан цэнэг хүнд 1 метр орчим ойр болсон үед



Усанд буюу нойтон газар цахилгаан цэнэг тархсан үед

### Аянганаас амь насаа хамгаалахын тулд юу хийх вэ?

- Барилга, гэр, байшингийн дотор байх хэрэгтэй
- Цахилгаан хэрэгсэл ашиглаж болохгүй
- Усны цоргоноос гараа угааж, онгоцонд усанд орж, шүршүүрт орж болохгүй. Усны цорго цахилгаан дамжуулна.
- Цонх, хаалганаас хол байх
- Бетонин ханыг налж эсвэл бетонин шалан дээр хэвтэж болохгүй. Энэ нь цахилгаан дамжуулна.
- Ямар нэг төмөр эд зүйлд хүрч болохгүй
- Задгай талбайд, уул, дов толгод дээр болон голын эрэг дээр байж болохгүй
- Мод, элдэв шонгийн дэргэд байж болохгүй
- Морь болон унаанаас бууж, доош суух

### Аянга, цахилгааны дараа юу хийх вэ?

- Хэн нэгэн аянганд ниргүүлсэн эсэхийг шалгах, тусламж дуудах
- Ил задгай унжсан цахилгааны утаснаас хол байх



### Аянга цахилгааны үед суух байрлал:

хөлийн өлмий дээр толгойгоо өвдөгний завсар хавчуулж аль болох хумигдан суух, биеийнхээ гадаргын талбайг болон газартай шүргэлцэх хэсгийг аль болох бага байлгахаар суух хэрэгтэй шүү...



Хамтдаа хийцгээе



### “Цахилгаан дамжуулах” тоглоом

Оролцогчид: 10-20 хүүхэд

Хэрэглэгдэх зүйл: байхгүй

- Нэг хүүхдийг өрөөнөөс гаргана. Бусад оролцогчид гар гараа барин тойрог болон зогсоно.
- Энэ үед тойрог болсон оролцогчид хэн нэгнийгээ онцолж, түүнээс эхлэн цахилгаан гүйхийг хэлнэ. Цахилгаан дамжуулж байгаа хүн дараагийн хүний гарыг чанга атгахад цахилгаан дамжиж байна гэсэн үг.
- Гаднаас нэг оролцогч өрөөнд орж ирж, тойргийн голд нүдээ аньж зогсоно.
- Тойргийн голд зогсч байгаа хүн нүдээ нээж, хаана хэн цахилгаан дамжуулж байгааг олно. Хэрвээ 1 удаагийн оролдлогоор олохгүй бол цахилгаанд цохиулж, 2 дахь удаагийн оролдлогоор олохгүй бол аянга, цахилгаанаас хэрхэн амь насаа хамгаалах аргаас хэлэх, харин 3 дахь удаагийн оролдлогоор олохгүй бол авьяасаа үзүүлэх эсвэл ямар нэг байдлаар шийтгэл хүлээнэ.
- Хэрэв олж чадвал цахилгаан дамжуулагчийн гараас барьж цахилгааныг таслана. Ингээд цахилгаан дамжуулж байсан хүнтэй байраа сольж зогсоно.

Үүнийг мэдэх үү



### Аянга, цахилгаанаас амь насаа аврах 30/30 дүрэм

Хэрэв цахилгаан цахилах, аянга нижигнэх хоёрын хоорондын хугацаа нь 30 секундээс доош /30 тоолохоос бага/ байвал та аюулд өртөж болзошгүй байна. Аянганы дуу хамгийн сүүлийн удаа сонсогдсоноос хойш 30 минутын турш гадаа гарч болохгүй.





## СЭДЭВ 8. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА



### Уншаад ярилцаарай

Хүүхдүүдээ та нар газар хөдлөлт яагаад болдогийг Хүн байгаль хичээлийг судлах явцдаа мэддэг болсон.

Газар хөдлөлт нь учруулах хөнөөл ихтэй, урьдчилан таамаглах боломжгүй, гэнэт асар богино хугацаанд тохиолддог хамгийн аюултай үзэгдэл тул газар хөдлөлтийн гамшигт бэлэн байдлаа хангаж, гамшгийн үед юу хийхээ мэддэг байх нь амь нас, эд хөрөнгө хохирохоос сэргийлж чадна.

Иймд өнөөдрөөс эхэлж газар хөдлөлтийн аюулаас хамгаалах арга ухаанд суралцаж эхэлье.

### Газар хөдлөлтийн аюулгүй ажиллгааны 7 алхам

1-р алхам: Гэр орон, сургууль дотор газар хөдлөлтийн үед аюул учруулж болзошгүй зүйлийг илрүүлж, засаж янзлах

Гэр орон, анги танхимаа аюулгүй болгохын тулд газар хөдлөлтийн чичирхийллийн үед унаад гэмтэл учруулж болох бүх зүйлийг шалгаж, дараах зурагт үзүүлсэн хэлбэрээр бөхөлж аюулгүй болгоорой.

Жаазыг хананд бэхлэх	Унаж хагарах эд зүйлийг тогтоох	Тавилгыг ханатай нь бэхлэх	Цахилгаан хэрэгслийг унахааргүй бэхлэх

2-р алхам: Газар хөдлөлтийн үед хэрхэн ажиллах төлөвлөгөөг хамтдаа хийх

3-р алхам: Төлөвлөгөөний дагуу дадлага хийх

### Газар хөдлөлтийн өмнөх бэлэн байдлыг төлөвлөх

өрөөний аюулгүй газрыг олж тогтоох, тухайн газарт богино хугацаанд хүрэх сургуулилт хийх

шаардлагатай хүнс, эм, дулаан хувцас, бичиг баримт зэргийг бэлтгэх


Гэр бүл, анги хамт олноороо хэлэлцэж боловсруулсан төлөвлөгөөгөө жилд нэг удаа дасгал сургуулилт хийж шалгаж байх хэрэгтэй. Энэхүү дасгал сургуулийг жил бүрийн 3 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагийн 16.00 цагт улс орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дадлага, сургалт хийж, бэлэн байдлыг хангах ажилтай нэг зэрэг хийж болохоор төлөвлөөрэй.



### 4-р алхам: Гамшгийн үед шаардлагатай эд зүйлсийг бэлтгэх

#### Хувийн эд зүйлс

- Анхны тусламжийн хэрэгсэл
- Нүдний шил, хувийн ариун цэврийн хэрэгсэл
- Савласан ус, илчлэг ихтэй хөнгөн хоол
- Шүгэл, бэлэн мөнгө, гар чийдэн, нөөц батерейн хамт гэх мэт




#### Өрхийн эд зүйлс /3-5 өдрөөр бодож бэлтгэх/

- Анхны тусламжийн хэрэгсэл, эм, бусад ариун цэврийн хэрэгсэл /саван, оо, алчуур, 00 цаас гэх мэт/
- Гар чийдэн, радио хүлээн авагч батерейн хамт, лаа, шүдэнз
- Ундны ус лаазалсан болон нөөжилсөн хүнс, хоолны хэрэгсэл, лааз онгойлгогч
- Майхан, хөнжил, дулаан хувцас, оймс, гутал
- Шаардлагатай бичиг баримтууд




### 5-р алхам: Газар хөдлөлтийн чичирхийллийн үед өөрийгөө хамгаалах /чичирхийлэл ихдээ л 1 минут үргэлжилдэг/

#### “ХЭВТ, НУУГД, ХҮЛЭЭ” - “DROP, COVER, AND HOLD ON.”



ХЭВТ



НУУГД



ХҮЛЭЭ

#### ГЭРТЭЭ БАЙВАЛ

ширээн доогуур ор, боломжгүй бол дэр, матрас зэргээр толгойгоо хамгаал

бүх төрлийн цахилгаан хэрэгслийг унтраах

#### ГАДАА БАЙВАЛ

цүнхээрээ толгойгоо халхалж ил задгай газар руу гүйх

барилгаас түргэн холдон хоосон зай, талбайд гарах

#### ОЛОН НИЙТИЙН ГАЗАР БАЙВАЛ

барьж яваа цүнх, эд зүйлсээрээ толгойгоо халхалж аюулгүй газар олох, цахилгаан шат ашиглаж болохгүй

гадагш гарах гарц руу яарах хэрэггүй, ажилтнуудын зааварчилгааг дага

#### СУРГУУЛЬ ДЭЭРЭЭ БАЙВАЛ

ширээн доогуур орох, эд зүйлээр толгойгоо халхал гэрлийн бүрхүүл, ханын шүүгээ, номын тавиур зэрэг нурж унаж болзошгүй зүйлээс хол байх



## 6-р алхам: Газар хөдлөлтийн дараа өөрийгөө болон орчин тойрноо шалгах Хэрэв та нурангин дор орсон бол:

### Бэртэл, гэмтэлээ шалгах

- Бусдад туслахаасаа өмнө өөрийгөө бэртэж, гэмтсэн эсэхийг шалгах
- Өөртөө болон бусдад анхны тусламж үзүүл
- Хүнд гэмтэлтэй хүнийг хамаагүй хөдөлгөж, тээвэрлэж болохгүй
- Бэртэж, гэмтэгсдэд шаардлагатай ус, дулаан хөнжил гудсаар туслах

### Аюултай нөхцлүүдийг шалгах

- гал гарч болзошгүй газруудыг шалгах, ил гал хэрэглэж болохгүй
- аюултай бодис, шингэн алдагдсан байхаас болгоомжлох
- ил гарсан цахилгаан утас, хагарсан шилнээс болгоомжлох

- Тайван байж орчин тойрноо ажиглаад гадна байгаа хүмүүст өөрийгөө мэдэгдэх арга хэмжээ авах хэрэгтэй .
- Гал гаргаж болохгүй, зөвхөн хашгирах юмуу хатуу биетээр хана цохиж мэдэгдэх
- Өөрийн тамир тэнхээгээ гамнах хэрэгтэй.
- Гэмтэж бэртсэн эсэхээ шалгаж шаардлагатай бол өөртөө анхны тусламж үзүүлэх



## Хамтдаа хийцгээе

Газар хөдлөлтөөс хамгаалах талаар олж авсан мэдлэгээ гэр, бүлийнхэндээ түгээх үүднээс гэр бүлийн гишүүдтэйгээ харилцан ярилцаж хамтдаа гэрийнхээ аюулгүй байдлыг хангах шалгах хуудсыг хийгээрэй.

**Гэр бүлийн шалгах хуудсаа хийхдээ дараах зааврыг ашиглана уу.**

## Аюулыг арилгах

Манай гэрийн газар хөдлөлтийн аюулгүй байдлын шалгах хуудас

Ор том, толь, шилэн жаазтай зураг, цонх, эд зүйл тавьсан олон тавиуртай тавилганы дэргэд эсвэл таазнаас өлгөөтэй гэрлийн бүрхүүлийн доор байрлаагүй	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>
Гэрийн тавилга, хэрэгсэл унаж хаалга таглахааргүй байрласан	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>
Гэрийнхээ хүнд тавилгыг орноос хол байрлуулсан	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>
Номын тавиур, хананы тавилгыг унахааргүй бат бөх бэхэлсэн	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>
Гал тогооны тавилганы шил, шаазан эдлэл бүхий шүүгээний хаалганд түгжээ хийсэн	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>





Хүнд шилэн гэрлийн бүрхүүлийг таазанд бат бөх тогтоосон эсвэл хөнгөн гэрлийн бүрхүүлээр сольсон	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>
Тавилганы дээд тавиурууд дээрх чичирхийллийн үед унаж аюул учруулж болзошгүй хүнд эд зүйлийг доод хэсэгт сольж байрлуулсан	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>
Цахилгаан хэрэгслийг унаж гэмтэхээргүй бөхөлж тогтоосон	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>
Хананд уран зураг, тасалгааны цэцэг зэрэг эд зүйлийг бат бөх тогтоосон	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>
Шилтэй эм, бусад шилтэй эд зүйлийг тавилганы доод хэсэгт түгжээтэй хаалгатай шүүгээнд байрлуулсан.	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>
Галд амархан шатдаг, тэсэрдэг эд зүйлийг аюулгүй газарт хадгалсан	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>
Өрхийн бэлэн байдлын багцаа бэлдсэн	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>
Гэх мэт олон зүйлийн жагсаалт гаргаарай.	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>

### Танай гэр бүл хамтдаа хэдэн болзошгүй аюулыг илрүүлсэн бэ?

Түүнийхээ жагсаалтыг гаргаарай. Энэ шалгах хуудсыг ашиглаж хагас жил тутамд нэг удаа гэр бүлээрээ газар хөдлөлтийн аюулгүй байдлаа шалгаж байгаарай.

### Ажлын үр дүнгээ танилцуулах, туршлагаа хуваалцах

Гэртээ газар хөдлөлтийн аюулгүй байдлыг хангах шалгах хуудасны дагуу хийсэн ажлынхаа фото зураг болон энэ шалгах хуудас ашиглахаас өмнө байсан фото зургийг авч харьцуулан харж, ангийн найз, нөхөд, хамт олондоо танилцуулж туршлагаа хуваалцаарай.

### Үүнийг мэдэх үү

Монгол Улсын нутаг дэвсгэрийн 80 гаруй хувь нь газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд хамаардаг ажээ. Монгол орны нутаг дэвсгэр дээр жилд 1000-1500 удаагийн газар хөдлөлт бүртгэгддэг ба эдгээрийн 3-4 хувь 130-50 удаа нь 3 ба түүнээс дээш магнитудын хүчтэй ба 3-5 удаагийн газар хөдлөлт нь 5 ба түүнээс дээш магнитудын хүчтэй хөдлөлтүүд байдаг.





## СЭДЭВ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ



### Уншаад ярилцаарай

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон түүнд туслах хүмүүс гамшгийн үед ямар бэлтгэл хангасан байх вэ?

Гамшгийн нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамгийн их тусламж хэрэгтэй байдаг. Иймд хүүхдүүд та нар бүлгийнхээ үйл ажиллагааны хүрээнд эдгээр иргэдэд гамшгаас хамгаалах арга ухааныг зааж сурган, тэднийг аюулгүй байдлаа хангах боломжийг олгоорой. Энэ хүрээнд олон ажлыг хийж болно. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд тэдгээр хүмүүс, гэр бүлийн гишүүдийг оролцуулан гамшгаас хамгаалах төлөвлөгөө хийж болно. Ийнхүү хамтарсан төлөвлөгөө хийх нь онцгой нөхцөл байдал үүсэхэд эдгээр хүмүүст туслах хөрш, найзууд, ажлын хамт олон, хамаатан садны сүлжээ бий болох ач холбогдолтой.

### Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөвлөгөөнд доорх зүйлсийг тусгаарай.

	<p>Шаардлагатай үед өөртөө туслах найз нөхөд, хөршдөө гэрийнхээ илүү түлхүүрийг өгөх хэрэгтэй.</p>
	<p>Гамшгийн үед хэрэглэх үүргэвч хаана байдгийг мэдэж байх ёстой.</p>
	<p>Чухал хэрэгцээт зүйлийнхээ жагсаалтыг үүргэвчиндээ хадгалж нэг хувийг нь туслах хүндээ өгөх /сонсголын төхөөрөмж, зай зэрэг тусгай тоног төхөөрөмж, сэлбэг, одоо хэрэглэж байгаа эмийн уух тун, худалдан авах газар, ууж буй эм, хийлгэж байгаа эмчилгээний тухай нарийн мэдээлэл, эмчилгээтэй харшлах зүйлийн жагсаалт</p>
	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний онцлог хэрэгцээний тухай бүртгэл байдаг. Энэ бүртгэлд байгаа эсэхээ шалгах. Ингэснээр гамшгийн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг түргэн олж, тусламж үзүүлэх боломжтой болдог.</p>
	<p>Өөрийн хөгжлийн бэрхшээлийг бичсэн бугуйвч, зүүлтийг зүүж яваарай. Эмнэлгийн тусламж хэрэгтэй байгаагаа хэлж чадахгүй байгаа тохиолдолд энэ мэдээлэл аврах болно.</p>
	<p>Хэрэв ямар нэгэн эмчилгээ, үйлчилгээ тогтмол авах шаардлагатай байдаг бол энэ эмчилгээ, үйлчилгээг авах нэгээс дээш эмнэлгийн байршлыг мэддэг байх, жагсаалтад бичсэн байх хэрэгтэй.</p>

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд нь тулгуурлан



гамшгийн эрсдэлийг бууруулах арга ухааныг зааж сургах хэрэгтэй.

### Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэнд бол:

- Сонсголгүй хүмүүст зориулсан утсан холбооны аппаратнаас 101, 103, 105 эсвэл орон нутгийн яаралтай тусламжийн дугаарт залгаж зай авах товчлуурыг тогшиж, ийм аппаратнаас залгаж байгаагаа ойлгуулаарай.
- Бусадтай харилцахын тулд бичих цаас, харандаатай явж байгаарай.
- Өөрийгөө хаана байгааг бусдад мэдэгдэх, мөн бусадтай харилцахдаа хэрэглэх зорилгоор гар чийдэнтэй явж бай.
- Анхааруулга, зааварчилгааг сонсож чадахгүй гэдгээ хөршдөө, найзууддаа сануулж, радиогоор өгч буй онцгой байдлын мэдээллийг өөртөө дамжуулахыг хүсээрэй.
- Орон нутгийн онцгой байдлын алба, Улаан загалмайгаас дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.



### Тэргэнцэр хэрэглэдэг иргэнд бол:

- Туслах хүндээ тэргэнцэрийг хэрхэн ажиллуулдаг, тэргэнцэр дээрээс хэрхэн буулгаж, суулгахыг зааж өгөөрэй. Ингэснээр тэд богино хугацаанд таныг зөөх боломжтой болно.
- Тэргэнцэр нь цахилгаанаар явдаг бол зай хураагуур хаанаас авч болох мөн түүнчлэн зөөвөрлөх шаардлага гарч болзошгүй учир тэргэнцэрийнхээ хэмжээг туслах хүнд хэлж өгөөрэй.
- Хэрэв өндөр байшинд амьдардаг, ажилладаг бол байшингаас шатаар бууж гарах шаардлага гарч болзошгүй. Тиймээс байшингаас гаргах ажлыг хөнгөвчлөх боломжтой тоног төхөөрөмж байгаа эсэхийг тодруулаарай. Онцгой нөхцөлд таныг байшингаас гаргаж өгөх хүмүүстэй урьдчилан тохиролцож, дадлага, сургуулилт хийгээрэй.



## СЭДЭВ 10. ГАМШГИЙН ҮЕ ДЭХ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

### Хамтдаа хийцгээе

Оршин суугаа баг, хорооныхоо нийгмийн ажилтан болон бүлгийн багштайгаа хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааг зохион байгуулаарай.

### Үүнийг мэдэх үү

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцоолсноор гамшгийн үед болон дараа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эрүүл, эрхтэн бүтэн хүүхдээс 10%-аар илүү амь насаа алдах тохиолдол байдаг. (UNICEF, 2001)





## Уншаад ярилцаарай

Хүүхдүүдээ та нар нас хүйс, нийгмийн гарал, шашин шүтлэг, хэнээс төрсөн, хаана байгаа зэргээс үл хамааран эрүүл, аюулгүй, аз жаргалтай, бүрэн дүүрэн амьдралаар амьдрах ёстой шүү дээ.

Гэтэл аливаа гамшгийн үед хүүхдүүд хамгийн ихээр нэрвэгддэг төдийгүй, нийгмийн хэвийн байдал алдагдсанаас болж хүүхдийн хамгаалуулах, сурч боловсрох гэх мэт олон эрхүүд нь зөрчигдөхөд хүрдэг. Учир нь хүүхэд бид бие бялдар, оюун ухааны төлөвшлийнхөө хувьд насанд хүрэгчдээс ялгаатай тул гамшгийн үед онцгой халамж анхаарал, хамгаалал шаардлагатай.

### Ямар ч гамшгийн үед хүүхдэд дараах хохирол, хүндрэл бэрхшээл учирдаг байна.

<ul style="list-style-type: none"> <li>• Бие махбодийн гэмтэл, хохирол</li> <li>• Эрүүл мэндийн хохирол</li> <li>• Сэтгэл зүйн хямрал, цочрол, дарамт</li> <li>• Эдийн засгийн хохирол, ядуурал</li> <li>• Эцэг эх, асран хамгаалагчаасаа тусгаарлагдах, ямар нэг халамж хамгаалалгүй үлдэх</li> <li>• Хүчирхийлэл тэр дундаа жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлд өртөх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэмт хэргийн золиос болох</li> <li>• Хүнд тэвчишгүй хөдөлмөр мөлжлөгт өртөх</li> <li>• Хүнс, хоол тэжээлийн дутагдалд орох</li> <li>• Орон байр, хувцас, бусад хэрэгцээ хязгаарлагдах</li> <li>• Боловсрол эзэмших нөхцөл хязгаарлагдах, тасалдах</li> <li>• Амь насаа алдах</li> <li>• Зэвсэгт бүлэглэлд татагдан орох</li> </ul>
--	---

Гамшиг, онцгой байдлын үед хүүхэд хүүхдээ хамгаалах чиглэлээр дараах ажлыг хийж чаддаг.

<p>5-10 насны хүүхэд Балчир хүүхдийг асран харж тоглуулах</p> <p>9-12 насны хүүхэд</p> <ul style="list-style-type: none"> <li>• Анхны тусламж үзүүлэх</li> <li>• Гэр бүлээсээ төөрсөн хүүхдийг асрах</li> <li>• Гомдсон уйтгартай байгаа хүүхэдтэй ярилцах</li> <li>• Хооллох, орчныг цэвэрлэх</li> <li>• Өөрөөсөө бага насны хүүхдийг сургах</li> <li>• Бага насны хүүхдийг асрах</li> <li>• Хүүхдэд тулгарч буй аюулын талаар бусдад мэдээлэх</li> <li>• Тусламжийн бараа тараах</li> </ul>	<p>12-17 насны хүүхэд</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бага насны хүүхдийг хамгаалж, туслах</li> <li>• Бага насны хүүхдийг асрах</li> <li>• Бага насныхан болон үе тэнгийнхнээ сургах</li> <li>• Гэмтэж, шархадсан хүүхдэд тусламж үзүүлэх</li> <li>• Гэмтэж, шархадсан хүүхдийг зөөх</li> <li>• Хүүхдийн орчныг цэвэрлэж, хооллох</li> <li>• Төөрсөн хүүхдэд гэр бүлээ олоход нь туслах</li> <li>• Хүүхдэд шаардлагатай мэдээлэл тараах</li> <li>• Хүүхдэд тулгарч буй аюулыг таслан зогсоох</li> </ul>
---	--



### Хамтдаа хийцгээе

Хүүхдүүдээ та нар манай оронд тохиолдож болох гамшгийн төрөл бүр дээр хүүхдэд нөлөөлж болох хохирол, хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, бид ямар хамгааллын ажлыг хийж чадах талаар танилцуулга хийн найз нөхөддөө танилцуулж болно.



### Үүнийг мэдэх үү



#### Улаанбаатар

☐☐☐☐	Гал
☐☐☐☐	Цагдаа
☐☐☐☐	Эмнэлэг
☐☐☐☐	Шуурхай бүлэг
☐☐☐☐	Хүүхдийн тусламжийн утас

#### Аймаг

☐☐☐☐	☐☐☐☐
☐☐☐☐	☐☐☐☐
☐☐☐☐	☐☐☐☐
☐☐☐☐	☐☐☐☐
☐☐☐☐	☐☐☐☐

### Хүүхэд бүр аюулгүй цэвэр орчинд амьдрах эрхтэй





## Өөрийгөө шалгаарай

1. Хүүхдүүдээ байгалийн аюулт үзэгдэл, хүний үйл ажиллагаатай холбоотой осол гамшиг болж хувирдаг нөхцлүүдийг нэрлэнэ үү?

А..... Б..... В.....

.....

### 2. Хүүхдүүдээ дараах бодомжуудыг зөв харгалзуулаарай

1. Цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ	А. Газар хөдлөлт
2. Учруулах хөнөөл ихтэй, урьдчилан таамаглах боломжгүй, гэнэт асар богино хугацаанд тохиолддог хамгийн аюултай үзэгдэл	Б. Ахуйн түймэр
3. Түлш, хүчилтөрөгчийн харилцан үйлчлэлээр бий болон гэрэл гаргаж, дулаан ялгаруулдаг химийн үзэгдэл	В. Хүчтэй салхи, шуурга
4. Хүүхдүүд төөрөх улмаар хөлдөх, осгох зэргээр амь насаа алдах аюултай.	Г. Ой хээрийн түймэр
5. Аянга, цахилгаан эсвэл хүний буруутай болон санамсаргүй үйлдлээс гардаг	Д. Зарлан мэдээллийн дохио
6. Бусад гамшгуудтай харьцуулахад урьдчилан сэргийлэх боломжтой	Е. Гал түймэр

### 3. Цаг агаарын гаралтай гамшгийн 6 нэрийг олно уу?

Г	И	Т	А	Р	Т	Й	В	О	Т	Ү	Л	И	Й	Н	Д	О	Л	Д	Ү
Е	П	З	А	Э	З	У	Д	Ү	О	Й	Х	Э	Э	Р	И	Ө	Б	В	Х
О	Н	Д	О	Г	О	Д	Ө	Г	П	Х	Э	Э	Д	Г	Й	М	Э	Р	О
Б	О	Л	Т	Ч	Т	А	Л	Ү	Л	Э	Р	Г	А	Д	Н	Р	Х	Ү	Й
Ч	Т	А	Ц	А	С	А	Н	Ш	Ч	Э	Ц	А	П	Ц	Т	Ү	Ж	Л	Х
Ү	Г	Я	Н	Г	А	К	Д	У	Р	Г	А	Н	А	Х	Ү	Е	Р	И	Ө
Л	О	Н	Д	Ж	Ө	С	Ш	У	У	Р	С	О	Ь	Ү	Й	Р	В	О	Р
Н	У	Г	Д	Е	Ц	А	С	Р	У	У	Д	М	П	Д	М	Ө	Д	Р	Д
А	П	А	О	Г	И	Д	О	Г	Р	Л	Ө	И	Ү	Й	Э	Р	Л	Ү	Ё
У	Ж	А	Г	Ү	Р	Г	У	А	Б	О	Л	С	Ж		Р	Т	О	Й	Б



#### 4.Зөв эсвэл буруу юу аль нь вэ?

1	ЗӨВ БУРУУ	гал түймрийн үед хүн амьсгалсан тохиолдолд үхэлд хүргэх утаа, хортой хий ялгарна
2	ЗӨВ БУРУУ	аянга, цахилгааны үед модны доор зогсох нь аюулгүй.
3	ЗӨВ БУРУУ	ой, хээрийн түймэр ихэнхдээ хүний буруутай болон санамсаргүй үйлдлээс гардаг
4	ЗӨВ БУРУУ	тог тасарсан үед гар чийдэн ашиглах нь лаа хэрэглэхээс илүү аюултай
5	ЗӨВ БУРУУ	гэр, байшин 5 хүрэхгүй минутийн дотор галын дөлөнд шатаж дуусна.

#### 5. Дараах санамжуудыг уншаад тохирох аюулын нэрийг нөхөж бичнэ үү. (аянга, ахуйн түймэр, хүчтэй салхи, шуурга, ой хээрийн түймэр)

**А**.....

Шүдэнз хүүхдийн гар хүрэхгүй өндөр газар хадгалах  
Залгуурын ачаалал хэтрүүлж болохгүй  
Бага насны хүүхдийг харах хүнгүйгээр гэрт үлдээж болохгүй  
Цахилгаан хэрэгсэл залгаатай орхиж огт болохгүй.

**Б**.....

Цаг агаарын байдлын талаар мэдээлэл сайн ав  
Боломжтой бол гэрээсээ бүү гар  
Малаа хашаа, хороонд нь оруул  
Дулаахан хувцасла

**В**.....

Цогтой үнс нурмаа битүү тагтай саванд хийх  
Тамхи, шүдэнзний галыг ил задгай хаяхгүй байх  
Гэр сууц, хашаа хорооныхоо гадуур хамгаалах зурвас татах  
Хуурайшилт ихтэй хавар, намрын үед хээр, хөдөө аялал зугаалгаар явахгүй байх

**Г**.....

Цахилгаан хэрэгсэл ашиглаж болохгүй  
Цонх, хаалганаас хол байх  
Ямар нэг төмөр эд зүйлд хүрч болохгүй  
Мод, шонгийн дэргэд байж болохгүй











## СЭДЭВ 1: ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Уншаад ярилцаарай

Хүүхдүүдээ хүмүүс бид гамшгийн эх үүсвэр болдог байгалийн аюулт үзэгдлийг зогсоож чадахгүй. Хэрвээ бид байгалийн үзэгдэл нь яагаад тохиолддогийг ойлгож мэдэх, бид юу хийвэл түүнд өртөж хохирол амсахгүй байх талаар илүү сайн ойлголтой болвол гамшиг болохоос урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Хүмүүс бид аливаа гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараа тодорхой зүйлийг хийж байж гамшгаас өөрсдийгөө хамгаалах, аливаа аюул ослыг хохирол багатай даван туулах боломжтой юм.

### Гамшгаас хамгаалахын тулд бид юу хийж чадах вэ?

Гамшгийн үе шат	Гамшгийн өмнөх үе	Гамшгийн үе	Гамшгийн дараах үе	
<b>Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа</b>	Урьдчилан сэргийлэх	Эрэн хайх-аврах	Хор уршгийг арилгах	Сэргээн босгох
<b>Үйл ажиллагааны үндсэн зорилго</b>	Гамшгийн эрсдэлийг бууруулах замаар гамшгаас үүсч болзошгүй сөрөг үр дагаврыг багасгах, гамшгийн үед шуурхай ажиллах бэлэн байдлыг хангах	Гамшгийн голомтод нэрвэгдэгсдийг эрэн хайх-аврах, яаралтай тусламж үзүүлэх,	Гамшгийг хамгийн бага хохиролтойгоор гэтлэн давахад чиглэсэн арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх	Гамшгийн голомт дахь хүн амын аж байдлыг хэвийн байдалд эргүүлж оруулах
<b>Үйл ажиллагаанд хамаарах арга хэмжээ</b>	Эрсдэлийг үнэлэх аюулыг бууруулах эмзэг байдлыг бууруулах бэлэн байдлын төлөвлөгөө хийх сургалт, дадлага хийх нөөцийг бүрдүүлэх зарлан мэдээлэл дамжуулах	Эрэн хайх аврах яаралтай тусламж үзүүлэх нүүлгэн шилжүүлэх	Хоргодох байр, хүнсээр хангах ус ундны хангалт хийх аруйн цэвэр, эрүүл ахуйг сахих	Хохирлыг тооцох, барагдуулах барилга, байгууламж, үйлчилгээг хэвийн байдалд оруулах



## Хамтдаа хийцгээе



### “Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” тоглоом

Найз, нөхөддөө гамшгаас хамгаалах үйл ажиллагааны талаар өөрийн мэдлэгээ хуваалцаж, хамтдаа энэхүү тоглоомыг тоглоорой.

**Оролцогчид:** 15-20 хүүхэд

**Орчин:** Ил задгай газар

Хэрэглэгдэх зүйл:

- 4-р хавсралтад үзүүлсэн Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг бүрдүүлэгч арга хэмжээнүүдийг нэг нэгээр нь бичсэн 18 картыг багийн тоогоор бэлтгэх
- УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ”, “АВРАХ”, “ХОР УРШГИЙГ АРИЛГАХ”, СЭРГЭЭН БОСГОХ” гэсэн үг бичсэн 4 цаасыг багийн тоогоор бэлтгэх

Хүүхдүүд 3-4 багт хуваагдана. Нэг багт 5 хүүхэд байхад тохиромжтой. Баг бүрт 18 картаас бүрдсэн нэг нэг багцыг, мөн “УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ”, “АВРАХ”, “ХОР УРШГИЙГ АРИЛГАХ”, СЭРГЭЭН БОСГОХ” гэсэн үг бичсэн 4 цаасыг өгнө.

Багийн хүүхдүүд шил шилээ харан зогсоно. Бичиг бүхий 18 картаа хүүхдүүдээс 10 метрийн зайтай газар тавих ба түүнээс цааш мөн 10 метрийн цаана “УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ”, “АВРАХ”, “ХОР УРШГИЙГ АРИЛГАХ”, СЭРГЭЭН БОСГОХ” гэсэн үг бичсэн 4 цаасаа байрлуулсан байна.

“Эхлээд” гэсэн дохио өгмөгц баг тус бүрээс нэг нэг хүүхэд гүйн гарч өмнөө байгаа картуудаас аль нэгийг нь аван “УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ”, “АВРАХ”, “ХОР УРШГИЙГ АРИЛГАХ”, СЭРГЭЭН БОСГОХ” гэсэн бичгийн доор харгалзуулан тавина. Үүний дараа буцан багтаа түрүүлж гүйж ирэх ба түүнтэй солилцон өөр нэг хүүхэд гарч гүйн өмнөх үйлдийг давтана.

Түрүүлж картаа дуусгасан зөв байрлуулсан баг хожно. Бүх картууд зөв ангилагдсан эсэхийг номтойгоо тулган шалгаарай.

## Үүнийг мэдэх үү



Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд хийгдэх нийт арга хэмжээний 50 хувь нь гамшгийн өмнөх үед тодруулбал урьдчилан сэргийлэх ажиллагаанд хамаардаг байна.





## СЭДЭВ 2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ТУХАЙ

### Уншаад ярилцаарай

Эрсдэл гэдэг бол аюулт үзэгдэл, осол гамшиг болж хувирах магадлал юм. Гамшгийн эрсдэл нь дараах 2 хэсгээс бүрдэнэ:

- 1. Аюул
- 2. Эмзэг байдал

Эмзэг байдал, аюул нь тус тусдаа байгаа тохиолдолд аюултай биш. Хэрвээ энэ хоёр хамтдаа байх үед эрсдэл үүсдэг бөгөөд өөрөөр хэлбэл гамшиг тохиолдох боломжтой болно

Аюулт үзэгдлийн нөлөөлөлд өртөж, эрсдэлийг нэмэгдүүлхүйц нөхцөл байдал, хүмүүсийн болгоомжгүй үйлдлүүдийг **эмзэг байдал** гэнэ. Жишээлбэл, голын сав газар, үерийн аман дээр буусан айлууд өндөрлөг газар буусан айлуудаас илүү эмзэг байдалтай байна.

Хүүхдүүдээ энэ зурагт аюул, эмзэг байдал нь аль вэ?



Дал модны жимс бол хүүхдийн хувьд АЮУЛ юм

Ингээд энэ хүүхэд том жимстэй /аюул/ дал модны доор хэвтсэн /эмзэг байдал/ байгаа нь ЭМЗЭГ БАЙДАЛ юм.

Дал модны доор хэвтэж байгаа хүүхэд дээр жимс унавал гэмтэх нь ЭРСДЭЛ юм.

Бид эрсдэлээ бууруулахын тулд юу хийж чадах вэ?

- 1-рт эрсдэлийн эх үүсвэрийг тогтооно.
- 2-рт энэ эрсдэлийг бид юу хийвэл арилгах, бууруулах боломжтойг тогтооно.
- 3-рт хийх боломжтой бүх зүйлийг хийж эрсдэлээ бууруулна.

### Эрсдэлийг хэрхэн бууруулах



Аюулыг арилгаж эрсдэлийг байхгүй болгоно



Аюулаас зайлсхийж эрсдэлийг бууруулна



Аюулын нөлөөллийг багасгаж эрсдэлээ бууруулна



### Хамтдаа хийцгээе



Хүүхдүүдийн дунд “Гамшгийн эрсдэл” гэсэн сэдвээр ГАР ЗУРГИЙН БОЛОН ЭССЕ БИЧЛЭГИЙН УРАЛДААН зохион байгуулаарай.

**Уралдааны зорилго** нь гамшгийн эрсдэлийн талаарх хүүхдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд оршино. Мөн үүний зэрэгцээ эцэг эх, багш, сургуулийн болон орон нутгийн удирдлагууд хүүхдийн нүдээр эрсдэл, эрсдэлийг бууруулах арга замыг олж харах боломжийг олгож байгаа юм.


**Уралдааны сэдэв** нь орон нутаг, улс оронд үүсч болзошгүй гамшгийн эрсдэл, түүний шалтгаан, эрсдэлийг хэрхэн бууруулах, хүүхэд юу хийж оролцох боломжтойг харуулсан чөлөөтэй байна. Сурагчид өөрийн үзэл бодол, төсөөллөө гар зургаар болон эссе бичих аль ч хэлбэрээр илэрхийлж болно.

**Уралдааныг дүгнэхдээ** бүх уралдаанд ирүүлсэн материалыг сургуулийн нийт сурагчдын дунд дэлгэн харуулж, хамгийн сайн болсоныг нь сонин, сэтгүүлд хэвлүүлж болно.

### Үүнийг мэдэх үү



Гамшгийн эрсдэлийг бууруулахад зарцуулсан 1 төгрөг тутам нь гамшгаас үүдэж гарах зардлын 7 төгрөг тутамтай тэнцдэг гэнэ. Тодруулбал, хэрвээ айл 1 үхрээ зараад өвс, тэжээл худалдаж авбал тэр өвс тэжээл нь өвөл 7 үхрийг элбэг тэжээж, өвөл хорогдохоос хамгаалах боломжтой.





## СЭДЭВ 3. НЭРВЭГДЭГСДИЙГ АВРАХ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ, ЗӨӨХ АЖИЛЛАГАА



### Уншаад ярилцаарай

Аврах ажлыг мэргэжлийн баг гүйцэтгэх боловч зарим тохиолдолд мэргэжлийн хүмүүсийг хүрэлцэн иртэл эсвэл мэргэжлийн баг хүрэлцээгүй үед эхний шатанд нутгийн иргэд, сайн дурухан, өсвөрийн аврагчдыг боломжийн хирээр татан оролцуулж болдог.

### Аврах ажиллагаа нь:



**Хүний амь насыг аврах бол энэ ажиллагааны нэн тэргүүний зорилт байдаг.**

Аврах ажиллагаатай барилга байгууламжийн нурангиас нэрвэгдэгсдийг эрэн хайх-аврах ажлаар төлөөлүүлэн танилцъя.

### **1. Нэрвэгдэгсдийг эрэн хайх**

Барилга байгууламжийн нурангинд дарагдсан нэрвэгдэгсдийг эрэн хайхдаа

- Аврах ажил хийх хэсгийг нийтэд нь нүдээр харж судлах
- Тусгайлан сургаж бэлтгэгдсэн нохой ашиглах
- Эрлийн тусгай аппарат багажийг ашиглах
- Гэрчийн (харсан хүмүүс) мэдүүлгийг ашиглах зэрэг аргыг хэрэглэж болно.

### **2. Заналхийлж буй аюулаас нь чөлөөлөх**

Нурангинд дарагдсан нэрвэгдэгчийг байгаа газраас нь шалтгаалан чөлөөлөх ажлыг дараах 3 төрлөөр явуулна.

#### Чөлөөлөх ажлын хэлбэр

- Барилгын хийц, хэлтэрхий дор дарагдсан нэрвэгдэгчийг чөлөөлөх
- Өрөө тасалгаанд дарагдаж түгжигдсэн нэрвэгдэгчийг чөлөөлөх
- Нурсан барилгын дээд давхараас нэрвэгдэгчийг аврах

#### Ажлыг гүйцэтгэх арга

- Нурангийг дэс дараатай зайлуулах
- Хонгил ухах
- Хана, хаалтанд нүх, цоорхой гаргах
- Бүтэн үлдсэн болон сэргээн засварласан шат ашиглах
- Аврах олс ашиглах, Аврах хоолой ашиглах



### 3. Амилуулах суурь тусламж үзүүлэх

Амилуулах суурь тусламж гэдэг нь нэрвэгдэгсдийг газар дээр нь гарын доорх хэрэгслийг ашиглан эмнэлгийн тусламжийг үзүүлэх арга хэмжээ юм.

Амилуулах тусламжийн үндсэн зорилго нь нэрвэгдэгсдийн амь насыг аврах, хөнөөх хүчин зүйлийн хортой нөлөөллийг арилгах, гамшгийн голомтын бүсээс тэднийг зөөж гаргахад бэлтгэх явдал юм.

Амилуулах суурь тусламж нэрвэгдэгсдийг амьд эсэхийг тогтоохоос эхэлнэ.

#### Амьд эсэхийг шалгах арга:

Шалгах хэлбэрүүд		Шалгах арга	Амьд байгаа шинж	Үхлийн шинж
Ухаан		Чихэнд нь ямар нэг үг чанга хэлэх буюу юм асуух	Хариу үзүүлэх	Хариу үзүүлэхгүй
Амьсгал		Цээжний хөдөлгөөн ажиглах, амьсгал чагнах, хөлрөх толь хэрэглэх	Амьсгалах	Амьсгалахгүй
Судас		Бугуй, гуя, гүрээний судсыг дарж судасны хананы түлхэх хэлбэлзлийг мэдрэх	Судасны цохилт мэдрэгдэх	Судасны цохилт мэдрэгдэхгүй
Хүүхэн хараа		Нүдрүү гэрэл тусгах	Хүүхэн хараа гэрэлд нарийсах	Гэрэл мэдрэхгүй томорсон байх

Эдгээр шинжүүдээс хоёр нь мэдрэгдэж байвал нэрвэгдэгч амьд байх тул амилуулах суурь тусламж үзүүлэх хэрэгтэй





**Дарагдсан нэрвэгдэгчдэд тусламж үзүүлэх анхан шатны арга:**

Эхний ээлжинд нэрвэгдэгчийн толгой, цээжийг даралт, шахалтаас чөлөөлнө.
Нурангид дарагдсан хөл, гарыг гаргахын өмнө буюу гаргасны дараа дараа аль болох богино хугацаанд дарагдсан хэсгээс дээгүүр чанга бооно.
Арьс зөөлөн эд гэмтэж, шархадсан бол чанга боолт тавьж цус тогтоох, түлэгдсэн хөлдсөн хэсгийг боох
Яс хугарсан бол чиг тавьж хөдөлгөөнгүй боох
Биеийн хатсан хэсэгт иллэг хийх
Хөлдсөн хэсгийг улайтал үрэх

Хэрвээ нэрвэгдсэн хүн туйлын хүнд буюу ухаангүй байвал сэхээн амьдруулах арга хэмжээ (хиймэл амьсгал, зүрхний шууд бус иллэг) яаралтай авах дохио болно. Хүүхдүүд та нар сэхээн амьдруулах арга хэмжээг хэрхэн авах мэдлэгийг эмнэлгийн ажилтны тусламжтайгаар эзэмшиж болно. Ингэхийн тулд бүлгийнхээ жилийн төлөвлөгөөнд тусгаад мэргэжлийн эмчээр заалгаарай.

**4. Аюултай бүсээс зөөж гаргах**

Нэрвэгдэгсдэд амилуулах суурь тусламж үзүүлсний дараа аюултай бүсээс эмнэлгийн байр руу доорх зүйлсийг ашиглан зөөнө.

Дамнуурга	 <p>Хэвтүүлэн зөөнө.</p>	Зөөлөн материал (гадуур хувцас, бүтээлэг)	Нэг үзүүрийг нь уяж, өвчтөнөө дээр нь хэвтүүлэн чирнэ.
Олс, бүс, алчуур	 <p>Хоёр гарыг нь холбон уяж өөрийнхөө шилэн хүзүүнд углан дөрвөн хөллөн мөлхөж зөөнө.</p>	Хавтгай төмөр, банз	Дээр нь хэвтүүлэн чирч болно.






Хамтдаа хийцгээе



Нэрвэгдэгсдийг зөөх буухиа тоглоом

Нэг баг нь 9 гишүүнтэй байхаар хүүхдүүдийг хуваана.


- Эхний 4 хүүхэд гараанаас гарч 20 метр гүйгээд мод, бүтээлэг, хувцас зэргийг ашиглаж гэмтсэн хүнийг зөөх дамнуурга хийнэ.
- Дамнуурга дээрээ гэмтсэн хүнийг хэвтүүлж 20 метр гүйж багийн дараагийн 4 гишүүн дээрээ гэмтсэн хүнийг зөөж авчирна.
- Дараагийн 4 гишүүн мод, бүтээлэг, хувцас зэргийг ашиглаж гэмтсэн хүнийг зөөх дамнуурга хийнэ.
- Шинэ дамнуурга дээрээ гэмтсэн хүнээ хэвтүүлж барианы газарт хүртэл 20 метр газрыг туулж гэмтсэн хүнийг хүргэж ирнэ.
- Буухиа тэмцээнийг хугацаагаар шүүнэ.



Үүнийг мэдэх үү



Эрэн хайх аврах ажиллагаанд хэрэглэгдэх үндсэн зангилаануудтай танилцаарай, бас зангидаж сураарай хүүхдүүдээ.





## СЭДЭВ 4. ӨРХИЙН БЭЛЭН БАЙДЛЫН БАГЦ



### Уншаад ярилцаарай

Хүүхдүүд та нар хичээлдээ явахдаа ном, дэвтрээ цүнхэнд эсвэл үүргэвчид хийдэг. Үүнтэй адил бид гамшиг тохиолдсон үед хэрэг болох зүйлсээ үүргэвч, цүнх, саванд хийж бэлдэх хэрэгтэй.

Гамшигийн үед хэрэглэх өрхийн бэлэн байдлын багц ямар хэрэгтэй вэ?

Гамшиг болсны дараа тусламж хэзээ ирэхийг хэлж мэдэхгүй. Тэгээд ч аврагчид бүх хүнд тусалж хүрэлцэхгүй шүү дээ. Бас цахилгаан, утсан холбоо, цэвэр ус хэдэн ч хоног тасалдаж магадгүй. Бас хэдхэн минутанд чухал хэрэгцээтэй зүйлээ аваад нүүх хэрэг гарч болзошгүй. Иймээс бид гамшигийн үед хэрэглэх өрхийн бэлэн байдлын багцыг бэлтгэснээр гэр бүлдээ учрах аюулыг багасгаж, гамшигийн үед тодорхой хугацаанд хэрэгцээт зүйлсээр дутагдахгүй байх боломжтой болно.

Гэртээ ямар зүйл бэлдэх хэрэгтэй вэ?

Өрхийн бэлэн байдлаа хангах	
1	Онцгой нөхцөл байдлын үед гэр бүлээрээ цуглах өөрийн гэрийн хамгийн аюулгүй газрыг олж тогтоох
2	Гэрийнхээ тойм зураглалыг гаргаж, өрөө тус бүрийн аюулгүйн гарц, замыг тэмдэглэх
3	Гэр бүлийн гишүүдэд хий, цахилгаан хэрэгслээ хэрхэн салгахыг зааж сургах
4	Яаралтай үед шаардлагатай утасны жагсаалтыг гарган суурин утасныхаа ойр байрлуулах
Онцгой нөхцөл байдлын үед хэрэглэх зүйлсээ бэлтгэх	
1	Цэвэр ус, лаазалсан болон амархан муудахааргүй хоол хүнс бэлтгэх
2	Дулаан хувцас, гутал, борооны цув, аяны хөнжил бэлтгэх
3	Анхны тусламжийн хайрцаг, ойр зуурын эм, гэр бүлийн зарим гишүүн тусгай эм бэлдмэл хэргэлдэг бол нэмж бэлтгэх
4	Банкны карт, бэлэн мөнгө, машины илүү түлхүүр, бичиг баримт бэлтгэх

*Шилжин нүүхэд хэрэг болох 3 хоногийн хоол хүнсний нөөцийг бэлэн байдлын үүргэвчиндээ, гэртээ 2 долоо хоногийн хүнс, усны нөөц байлгаарай.*

*Шилжин нүүх бол хүн тус бүрт 11 литр ус, гэртээ хоргодож байгаа бол хүн тус бүрт 15 литр байхаар тооцож бэлтгэнэ.*









## Гамшгийн үед хэрэглэх хүн нэг бүрийн үүргэвчид юу байх ёстой вэ?

Энэ үүргэвчид гамшиг тохиолдсон үед гэр бүлийн гишүүдэд шаардлагатай үндсэн хэрэгцээний зүйл байх ёстой. Үүргэвч нь авч явахад зохимжтой байх бөгөөд үүргэвчээ гарах хаалганд ойрхон байрлуулаарай. Гамшгийн үед та гэртээ хоргодох болсон ч, нүүх шаардлагатай байсан ч үүргэвч гарын дор бэлэн байх ёстой. Хэрэгцээт зүйлээ нөөцлөх нь гамшгийн дараа танай гэр бүлд хэрэг болно.

### Хүн нэг бүрийн үүргэвчид байвал зохих зүйлсийн жагсаалт

	<p>Ус: унданд хэрэглэх, шарх цэвэрлэх, нүүр гар угаах зориулалттай</p>
	<p>Лаазалсан болон хатаасан, удаан хугацаагаар хадгалах боломжтой, хэрэглэхэд хялбар хоол хүнсийг өдөрт 3 удаа 3 хоног хэрэглэхээр тооцож бэлдэнэ</p>
	<p>Хүн бүрт 1 ээлжийн солих хувцас, гутал, борооны цув, малгай бээлий, дулаан, нүдний шил, тоосноос хамгаалах амны хаалт зэрэг цаг агаар, улиралтайгаа зохицсон бусад хувцас</p>
	<p>Сонинг биеийн дулааныг хадгалах, яс хугарсан, гэмтсэн үед чиг барих, ороох боох, гал гаргах зориулалтаар ашиглана</p>
	<p>Очиж болох газруудаа утасны дугаартай нь тэмдэглэсэн газрын зураг</p>
	<p>Анхны тусламжийн цүнх: байнга хэрэглэдэг эм, жороор болон жоргүй олгодог эмнүүд, ороох боох материал</p>
	<p>Жолооны үнэмлэх, ажлын газрын үнэмлэх, зээлийн карт зэрэг чухал баримт бичгүүдийн хуулбар. Таныг хэн болохыг тодорхойлох, гэр бүлийн бусад гишүүдтэй холбоо барих, төрийн болон банк, санхүүгийн үйлчилгээ авахад ашиглана.</p>
	<p>Хэрэв нялх хүүхэдтэй бол хүүхдийн тэжээл, живх, сүүний сав, соско, эм зэрэг хөргөгчид хадгалах шаардлагагүй зүйлс</p>



	Нүдний шил, сонсголийн төхөөрөмж, түүний зай гэх мэт чухал хэрэгцээт зүйлс
	Зайгаар ажилладаг зөөврийн радио. Мэдээ мэдээллийг шуурхай хүлээн авах зориулалттай. (тэжээлийн эх үүсвэртэй байх)
	Гэрэлтүүлэх, дохио өгөх зориулалттай гар чийдэн, шинэ зай
	Цаас, харандааг шаардлагатай тэмдэглэгээ үлдээхэд ашиглана.
	Лаа, шүдэнзийг гэрэлтүүлэх, дохио өгөх, хоол боловсруулахад ашиглана.
	Шүгэл. Дохио өгөхөд ашиглана.
	Ном, тоглоом зэрэг цаг өнгөрүүлэхэд тустай зүйлс



### Үүнийг мэдэх үү

Хүүхдүүдээ гамшгийн бэлэн байдлыг хангах ажилд та нар биечлэн оролцож аав, ээждээ туслаарай. Үүргэвчид юу бэлтгэх ёстой, бэлдсэн зүйлээ хаана тавих, бэлтгэсэн хүнсний зүйлсийн хадгалалтын хугацаа, хэзээ дуусах зэргийг мэдэж аав ээждээ сануулах нь гэр бүлдээ үзүүлэх маш том тусламж юм шүү. Нөөцөлсөн усаа 6 сар тутам сольж шинэчилнэ. Радио болон гар чийдэн зэргийнхээ зай, анхны тусламжийн хайрцагт байгаа эмнийхээ мөн хугацааг нь харж сэлгэлт хийнэ.



## СЭДЭВ 5.ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБА

Уншаад ярилцаарай



Бэлгэдэл



ОНЦГОЙ  
БАЙДЛЫН АЛБА

Гурвалжин - иргэний хамгаалалтын олон улсын таних тэмдэг болох улбар шар өнгөтэй гурвалжин дүрс,  
Дэлхийн бөмбөрцөг - хүн төрөлхтөн нэг гариг ертөнцийн нэгдмэл гэр бүл бөгөөд гамшгаас хамгаалах нь зөвхөн нэг улс, үндэстний бус нийт улс орон, хүн ардын үйл ажиллагаанаас харилцан хамааралтай нийгэм, эдийн засаг, тогтвортой хөгжил, байгаль экологийн асуудал гэсэн утга санааг илэрхийлнэ.  
Дэлхийн бөмбөрцгийг эмжсэн чидун жимсний мөчир - ялалт, амжилтыг бэлгэдэх ба мөнхөд оршихуйн утга санааг илэрхийлнэ.  
Гурвалжин дүрсний төв хэсэг дэх "Соёмбо" тэмдэг нь тусгаар тогтносон, бүрэн эрхт, эртний түүх, соёл, төр ёсны арвин баялаг уламжлал бүхий Монгол Улсын үндэсний онцлогийг илэрхийлнэ.



Хүүхдүүд та бүхэн Онцгой байдлын албаны тухай хэр ихийг мэдэх вэ?

Онцгой байдлын алба улс орон, ард иргэдээ болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үндсэн зорилготой төрийн байгууллага.

**"БИД ХАМГААЛНА, АВАРНА, ТУСАЛНА"** гэсэн уриатай иргэдээ гамшгаас хамгаалах үүргээ нэр төртэй гүйцэтгэсээр ирсэн хамт олон юм.

Онцгой байдлын алба хэзээ байгуулагдсан вэ?

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр тогтоолоор Улсын иргэний хамгаалалтын






газар, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын нөөцийн газрыг нэгтгэж, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зорилго бүхий Онцгой байдлын албыг байгуулсан.

- Улсын иргэний хамгаалалтын газар
- Гал түймэртэй тэмцэх газар
- Улсын нөөцийн газар



Гамшгаас хамгаалах ерөнхий газар  
(2004 он)



 Онцгой байдлын ерөнхий газар 2005 он)



### Хамтдаа хийцгээе


Хүүхдүүдээ онцгой байдлын албаны талаар илүү их мэдлэгтэй болохын тулд орон нутгийнхаа онцгой байдлын албаны мэргэжилтнийг урьж ирүүлэн дэлгэрэнгүй танилцуулга хийх, сонирхсон асуултандаа хариулт авах ажлыг жилийн төлөвлөгөөндөө оруулан төлөвлөн хийж болно.

Мөн бүлгийн гишүүд мэдээллийн хэрэгсэл /телевиз, сонин, сэтгүүл, интернэт гэх мэт/ болон номноос онцгой байдлын албаны талаар мэдээлэл цуглуулан танилцуулга бэлтгэж мэдээллээ бусдадаа хуваалцаж болно.

Сургуулийн нийт хүүхдүүдийн дунд “Миний мэдэх онцгой байдлын алба” гар зургын болон эссе бичлэгийн уралдаан зарлаж дүгнэж болно. Амжилттай оролцсон хүүхдийг онцгой байдлын албаны мэдээллийн цагаар сурталчилаарай.



### Үүнийг мэдэх үү





## СЭДЭВ 6. АВРАГЧ, ГАЛ СӨНӨӨГЧ МЭРГЭЖИЛ

### Уншаад ярилцаарай



Аврагчид гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод шуурхай шилжин байрлаж, эрэн хайх, аврах ажлыг явуулах, нэрвэгдэгсдэд бүх төрлийн яаралтай тусламж үзүүлэх, тэднийг аюулгүй газарт зөөвөрлөн гаргах, эд хөрөнгийг хамгаалах үүрэг гүйцэтгэдэг.

Онцгой байдлын албанд аврагч, гал сөнөөгч, шүхэрчин- аврагч, десантчин-аврагч, аврагч-усчин, аврагч-химичин, аврагч-холбоочин, аврагч-тэсэлгээчин, аврагч-жолооч зэрэг төрөл мэргэжлийн аврагч үүрэг гүйцэтгэдэг.



- Аврагч - УСЧИН
- Аврагч - Шүхэрчин
- Аврагч - Гал сөнөөгч



Аврагчид аврах ажиллагаандаа олон төрлийн багаж, хувцас хэрэгсэл ашигладаг.





### Хамтдаа хийцгээе

Аврагч, гал сөнөөгч мэргэжил эзэмшихийн тулд ямар сургуульд суралцах, ямар ур чадвар эзэмшсэн байх шаардлагатай тухай ярилцаарай.

Аврагч, гал сөнөөгч мэргэжлийн талаар илүү их мэдлэгтэй болохыг тулд орон нутгийнхаа Онцгой байдлын хэлтэстэй хамтран гал унтраах анги дээр очиж гал унтраах ангийн ах, эгч нартайгаа хамтран ажиллаарай.



### Үүнийг мэдэх үү

Хүүхдүүдээ аврагч, гал сөнөөгчдийн ашигладаг машин, багаж хэрэгсэлтэй танилцахдаа та нар орон нутгийнхаа Онцгой байдлын газар, хэлтэстэй доорх утсыг холбогдож болно.

Салбарууд	Дуудлага хүлээн авах утас	
Улаанбаатар хот Мэдээлэл, шуурхай удирдлагын төв	101	105
Архангай	7033101	7033105
Баян-Өлгий	7042101	-
Баянхонгор	7044101	7044105
Булган	7034101	-
Говь-Алтай	7048101	7048105
Говьсүмбэр	7054101	96540105
Дархан-Уул	7037101	7037105, 96370105
Дорноговь	7052101	96520105
Дорнод	7058101	96580105
Орхон	7035101	70350001
Өвөрхангай	7032101	96320105
Өмнөговь	7053101	96530105
Сүхбаатар	7051101	96921101
Сэлэнгэ	7036101	96360105
Төв	7027101	-
Увс	7045101	96450106
Ховд	7043101	96430105
Хөвсгөл	7038101	-
Дундговь	7059101	-
Завхан	7046101	96460105
Хэнтий	7056101	-






## СЭДЭВ 7. ГАЛ УНТРААХ АНХАН ШАТНЫ БАГАЖ ХЭРЭГСЭЛ, ГАЛ УНТРААГУУРЫГ АШИГЛАХ АРГА

Уншаад ярилцаарай



Гал гарсан тохиолдолд “түргэн тусламж” маягаар ямар ч хүн ажиллуулан галын анхны эх үүсвэрийг унтраах боломжтой зөөврийн багаж хэрэгслийг гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл гэнэ.



Хамгийн түгээмэл хэрэглэгддэг анхан шатны багаж хэрэгсэл бол гал унтраагуур (галын хор) юм.

Гал унтраагуур гэдэг нь гал унтраах бодисыг галын голомт руу цацсанаар галын дөлийг дарах, галыг агаар (хүчилтөрөгч)-аас тусгаарлах замаар галыг бага дээр нь түргэн унтраах зориулалттай зөөврийн ба хөдөлгөөнт төхөөрөмж юм.

Ахуйн хүрээнд хамгийн түгээмэл хэрэглэгддэг зөөврийн гал унтраагууртай танилцъя.





Зөөврийн гал унтраагуур нь (20 кг-аас бага хэмжээтэй) цилиндр хэлбэрийн металл сав, шүрших хоолой, бариул, гал унтраах бодис дамжих хоолойтой байдаг.

Зөөврийн гал унтраагуурын бүтэц	Гал унтраагуурын цэнэгтэй эсэхийг шалгах даралт хэмжигч
<p style="text-align: center;"><b>БҮТЭЦ</b></p>	<p style="text-align: center;"><b>Даралт хэмжигч манометр</b></p> <p style="text-align: center;"> <span style="color: green;">●</span> -ажилтай/даралттай/  <span style="color: red;">●</span> -ажилгүй/даралтгүй/  <span style="color: yellow;">●</span> -хяналтын хил         </p>

Галын хор цэнэг муутай бол сайн ажиллахгүй. Иймд галын хорыг солих эсвэл мэргэжлийн байгууллагад хандан цэнэглүүлэх хэрэгтэй шүү.

**Галын хорыг ашиглан гал унтраахын өмнө дараах арга хэмжээг авсан байх ёстой:**

- Хүн бүр гэрээс гарсан
- Гал сөнөөгчдийг дуудчихсан
- Галын хэмжээ бага бөгөөд тархахгүй байгаа
- Та үүд рүү нуруугаа харуулсан зогсож байгаа бөгөөд шаардлагатай үед хурдан гарч чадна
- өрөөнд их хэмжээний утаа байхгүй



### Хамтдаа хийцгээе



Сургуулийнхаа гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг бүртгэн зохистой, байрлуулах, ач холбогдлыг нь найз, нөхөд, багш ажилчиддаа тайлбарлах, таниулах. Дутуу багаж хэрэгслийг нөхөн бүрдүүлэх зэрэг ажлыг бүлэгийн гишүүд хамтран хийж болно.

Орон нутгийнхаа бусад байгууллага, албан газруудад гал унтраах анхан шатны багаж, хэрэгслийг хэрхэн ашиглах, байрлуулах талаар зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулаарай.

### Үүнийг мэдэх үү



Гал унтраах үед ихэнх зөөврийн галын хорны цэнэг 8 секундэд дуусдаг тул галыг дөнгөж гарч эхлэх үед л галын хорыг ашиглаж болно шүү хүүхдүүдээ. Галын хорыг дуусмагц гал унтраагүй үед түргэн байрнаас гарах хэрэгтэй.

Гал унтраагуур нь олон төрөлтэй байдаг бөгөөд эдгээр төрлүүд нь өөр өөр галыг унтраах зориулалттай юм байна.

### Гал унтраагуурын төрөл, тэдгээрийг хэрхэн таних вэ?

Галын хорны төрөл		Галын төрөл				
Төрөл	Өнгө	Хатуу биет \ мод, цаас, даавуу гэх мэт\	Шатамхай шингэн	Шатамхай хий	Цахилгаан хэрэгсэл	Өөх, тос
Ус		✓ унтраана	✗ унтраахгүй	✗ унтраахгүй	✗ унтраахгүй	✗ унтраахгүй
Хөөс		✓ унтраана	✓ унтраана	✗ унтраахгүй	✗ унтраахгүй	✓ унтраана
Нунтаг		✓ унтраана	✓ унтраана	✓ унтраана	✓ унтраана	✓ унтраахгүй
Хийн CO <sub>2</sub>		✗ унтраахгүй	✗ унтраахгүй	✗ унтраахгүй	✓ унтраана	✓ унтраана





## СЭДЭВ 8. ГАЛ ТҮЙМРИЙН ҮЕД АМЬ НАСАА ХАМГААЛАХ АРГА, ТҮЛЭГДЭЛТЭНД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ



Уншаад ярилцаарай



Гал түймрийн үед амь насаа хамгаалах арга

- Утааны үнэр гарвал аль болох хурдан шалан дээр хэвтээд, мөлхөх /хортой утаа нь шалнаас 70 орчим см-ын өндөрт тогтож байдаг/
- Хаалганд хүрмэгц шууд онгойлж болохгүй. Бариуланд болгоомжтой хүрээрэй. Бариул халуун байх нь цаана нь гал байгаагийн шинж шүү.
- Хаалга бүлээн байвал бага зэрэг онгойлгоно. Учир нь агаарын урсгал галыг өдөөдөг учраас өрөөний гал улам нэмэгдэж болно.
- Хаалганы цаана гал байхгүй бол хаалгаа бага багаар онгойлгож өрөөнөөс хурдан гараарай. Өрөөнөөс гарангуут хаалгаа хурдан хаана. Гарсан газар болгоны хаалгыг хааж явах хэрэгтэй. Энэ нь галын тархалтыг хязгаарлана.
- Гудамжинд гармагцаа 101 дугаар руу залгах, бусдаас тусламж хүсэх
- Хэрвээ гарах хаалганы цаана гал байвал хаалгаа сайн хааж, завсар зайг нь нойтон хувцас, алчуураар бөглөж, утаа оруулахаас хамгаална.
- Үүний дараа цонхоо онгойлгож тусламж хүсэн хашгирна. Ингэхдээ аль болох их дуу чимээ гаргаж хүмүүсийн анхаарлыг татах хэрэгтэй.
- Хэрвээ цонх чинь онгойхгүй тохиолдолд хүнд эд зүйлээр шилийг нь хагалан тусламж дуудаарай.
- Галын машин иртэл алчуур, цамц гэх мэт зүйлийг норгож ам хамраа хамгаалаарай.



- Хамгийн гол нь сандарч тэвдэлгүйгээр явган шатаар бууж гадагшаа гараарай. Хэзээ ч цахилгаан шат ашиглах хэрэггүй.



**Хэрэв таны хувцас галд автсан бол:**



- Газар хэвтэж өнхөрөх
- Гүйж болохгүй

**Гал намжсаны дараа:**

- Биеийн түлэгдсэн хэсэг дээр 3-5 минутын турш хүйтэн ус гоожуулах
- Эмнэлгийн байгууллагад хандах

Хүний биеийн аль нэг хэсэг галын дөл, халуун шингэн, халуун уур, улайтсан төмөр зэргийн нөлөөгөөр арьс болон арьсан доорх өөхөн эд, эрхтэн гэмтэхийг түлэгдэлт гэнэ.



**Түлэгдэлтэнд үзүүлэх тусламж**

Түлэгдэлтийн улмаас үүссэн гэмтлийн байдал нь

- Түлэгдэлт юунаас болж үүсэв /галын дөл үү, халуун уур уу гэх мэт/
- Хаана түлэгдсэн /толгойд уу, хөлд үү гэх мэт/
- Хэр зэрэг талбай хамарсан /биеийн гадаргуугийн гуравны нэг нь түлэгдэхэд хүн голдуу үхдэг/
- Түлэгдсэн хүний нас /том хүн эсвэл хүүхэд үү/
- Түлэгдсэн хүний эрүүл мэндийн байдал /эрүүл хүн үү, архаг өвчтэй хүн үү/ зэргээс шалтгаална.

**Түлэгдэлтийн зэрэг, тусламж үзүүлэх арга**

Түлэгдэлтийн эзлэх талбайн хэмжээ, арьсны эд, эсийн хэр гүн гэмтсэнээр нь түлэгдэлтийг 4 зэрэг болгон хувааж үздэг.

Зэрэг	Арьсанд илрэх шинж тэмдэг	Зураг	Тусламж үзүүлэх арга
I	Арьс улайна Бага зэрэг хавдана Хорсож өвдөнө		Хүйтэн усанд дүрж эсвэл хүйтэн ус гоожуулан 10 минутаас доошгүй хугацаагаар байлгах Хүйтэн жин тавих Шаардлагатай бол цэвэр хуурай боолт хийх
II	Улайж хавдана Цэврүү үүснэ Түлэгдсэн хэсэг чийгтэй харагдана Хүчтэй өвдөнө		I зэрэгт үзүүлсэн тусламжийг үзүүлнэ. Шархны байрлал хэмжээнээс хамаарч эмнэлгийн тусламж шаардлагатай байж болно.
III	Арьсны зөөлөн эд гүн гэмтэнэ Түлэгдсэн хэсэгт арьс үхжиж цагаан, хар толбо харагдана Өвчин багасаж, хордлого илэрнэ		Өвчин намдаах эм, шингэн зүйл уулгах Түлэгдсэн хэсэгт хүрч болохгүй Нүүрний хэсэг түлэгдсэн бол суугаа байрлалд байлгах Гар, хөл түлэгдсэн бол толгойноос өндөр байрлуулах
IV	Арьс булчин түлэгдэх төдийгүй ясандаа хүртэл түлэгдэж нүүрсжинэ.		Амьсгалын замыг чөлөөтэй байлгах Наалдахгүй материалаар шархыг боох Нүүр, гар хөлийн түлэгдэлтэнд хүйтэн жин тавих Яаралтай эмнэлэгт хүргэх





## Хамтдаа хийцгээе

Найз, нөхөддөө гал түймрийн үед амь насаа хэрхэн хамгаалах талаар зааж сурган, хамтдаа дараах тоглоомыг тоглоорой.

### “Яагаад гэвэл ... Яагаад” тоглоом

Оролцогчид: 15-30 хүүхэд

Хэрэглэгдэх зүйл: карт, үзэг

- Оролцогчдыг 2 эгнээ болгоод, өөд өөдөөс нь харуулан зогсооно. Хэсэг тус бүрт карт өгнө.
- 1-р хэсэг картан дээрээ гал түймрээс урьдчилан сэргийлэх арга, гал унтраах багаж хэрэгсэл, гал түймрийн үед амь насаа хамгаалах, галд түлэгдсэн хүнд тусламж үзүүлэх арга зэрэгтэй холбоотой “яагаад” гэсэн үгээр эхэлсэн асуулт бичиж, нөгөө хэсэг нь картан дээрээ “яагаад гэвэл” гэсэн үгээр эхэлсэн хариулт бичнэ. Жишээлбэл, Асуулт - **Яагаад** хувцасанд гал авалцсан тохиолдолд гүйж болохгүй вэ? Хариулт – **Яагаад гэвэл** галын дөлийг нэмэгдүүлнэ.
- “Яагаад” гэсэн асуулт бичсэн хэсэг асуултаа уншина. “Яагаад гэвэл” гэж хариулт бичсэн хэсэг зөв хариулт таартал уншина.



## Үүнийг мэдэх үү

Түлэгдэлтийн үед дараах зүйлийг хийж болохгүй шүү!

- түлэгдсэн хэсэгт цас мөс тавих
- түлэгдсэн хэсгийн арьсан дээр үүссэн цэврүүг хагалах
- түлэгдсэн хэсэгт наалдсан хувцасыг хуулах
- түлэгдсэн хэсэг дээр хөвөн материал тавих

Түлэгдэлтийн үед дараах тохиолдолд яаралтай эмнэлэгт хүргээрэй

- гарын алганаас том хэмжээтэй II зэргийн түлэгдэлт
- нүүр болон үен дээр байрласан түлэгдэлт
- биеийн аль ч хэсэгт байрласан III зэргийн түлэгдэлт
- амьсгалын болон хоол боловсруулах замын түлэгдэлт
- хүүхэд болон хөгшин хүмүүс түлэгдсэн



## СЭДЭВ 9. ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, УНТРААХ АРГА

Уншаад ярилцаарай



Хүүхдүүдээ хэрвээ амьдарч буй газраа ой, хээрийн түймрийн эрсдэлтэйг мэдвэл галд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал гарсан үед юу хийхээ мэддэг байх нь чухал шүү.

Ой, хээрийн түймрээс эд хөрөнгөө хэрхэн хамгаалах вэ?

- Ой, өвс ургамал бүхий газарт буусан, байрласан айл орчныхоо мод,өвсийг хааш хаашаа 200 метр хүртэл газар цэвэрлэсэн байх
- Гэр, байшин, хашаа хороогоо ой, хээрийн түймрээс хамгаалах аюулгүйн зурвас татах
- Пийшингийн яндангаас модны салаа, мөчрийг 3 метр хол зайд байлгах
- Зуухны үнсийг төмөр саванд хийж, норгож, сайтар унтраасны дараа газарт булах
- Хог хаягдал, сонин цаасыг болгоомжтой шатаах
- Түлшний модыг гэрээсээ өөд газарт 9 метр зайд хураах. Мод хураасан газрынхаа эргэн тойронд 6 метр хүртэлх зай талбайн шатаж болзошгүй зүйлийг цэвэрлэх
- Боломжтой бол гэрийнхээ гадаа худаг, усан сантай болж, гэрт болон гэрийн гадаах байгууламжийн аль ч хэсэгт хүрэхүйц хангалттай урт хэмжээний услуууртай байх
- Хүрз, сүх, хөрөө, хувин, тармуур, элс зэрэг галын үед ашиглаж болохуйц багаж хэрэгслүүдтэй байх
- Гэртээ гал унтраах хэрэгсэлтэй байх, хэрхэн ашиглахыг мэддэг байх

Ой, хээрийн түймрийн үед хэрхэн амь насаа аврах вэ?:

- Мэдээллийг цаг алдалгүй авч мэргэжлийн хүмүүсийн заавар, зөвлөгөөг дагах шаардлагатай бол орон гэрээ орхиж нүүх
- Аюулт тулгарсан үед ухсан нүх зэрэг хоргодох газарт орж амиа хамгаалах
- Хоргодох байр сав байхгүй тохиолдолд галд тэсвэртэй эсвэл зузаан материал бүхий бүтээлгийг норгон нөмөрч амиа хамгаалах

Ой хээрийн түймрийг унтраах арга

Ой хээрийн түймрийг гарч байгаа эхний үед унтраах нь хамгийн хялбар. Ой, хээрийн түймрийг унтраах ажил нь түймрийн шатлагын үе шат ямар байгаагаас хамаарч янз бүр байна.





## Ой хээрийн түймрийг дараах аргуудаар унтраадаг юм байна

<b>Дөлийг цохих</b>	Түймрийн зах хөвөөний дөлийг мөчир болон бусад гарын доорх эд зүйлээр (хаймар, шуудай, даавуу, цэмбэ зэрэг эд зүйлийн өөдсийг модон ишэнд бэхэлсэн цохиур) цохиж унтраадаг. Цохихдоо мөчир болон цохиурын чиглэл нь дөлний уг руу гулсуулж цохидог.
<b>Шороо цацах</b>	Түймрийн хүчийг харгалзан хөрсний өнгөн хэсгийг 0.5 -1 метр ба түүнээс дээш өргөнтэйгээр хуулж шороог хүрээр авч, дөлний уг руу аль болох их тархах дөлийг дарж унахаар цацдаг.
<b>Зурвас татах</b>	Хүрз, тармуур ашиглан гараар ба машин, техникээр хөрсийг ухаж бага хэмжээний түймрийн үед зурвасыг 0.5 метр, их хүчтэй үед 1 метр ба түүнээс дээш өргөнтэйгээр хийнэ.
<b>Усаар унтраах</b>	Шингэн зөөж болох гарын доорх хэрэгсэл (хувин, ямар ч зориулалтын сав) болон түймэр унтраахад зориулсан үүргэвчин шүршигч, ус тээврийн автомашин зэргийг ашиглаж шатах материалыг чийглэн унтраана.
<b>Цуравдах</b>	Түймрийн замд орших ямар нэгэн гол горхи, зөрөг зам зэрэг газрыг ашиглан эсвэл хориг зурвас татаж түймрийн эсрэг өвсийг шатаана. Түймэр ба цуравны гал нийлмэгц дөл асар өндөр боломж үлэмж дуу гарган унтардаг. Мэргэжлийн хүний тусламжтайгаар хийнэ.



## Хамтдаа хийцгээе

### Гал унтраах буухиа тэмцээн

Нэг баг 16 хүүхэдтэй байна.

- Багийн эхний 8 хүүхэд дүүрэн устай хувинг гурван саадыг давуулан авчирч галыг унтраахаар асгах
- Бусад 8 гишүүн нь хоосон хувинг 2 саад дамжуулан усны эх үүсвэрт хүргэх
- Унтраах ёстой нийт 9 галын дөл байна.
- Буухай тэмцээний дүн багийн гал унтраасан хугацаанаас хамаарна.







## Үүнийг мэдэх үү



Хүүхдүүдээ түймэр шөнө бидэнтэй адилхан унтдаг гэнэ шүү. Иймээс шөнийн цагт түймрийг их амархан унтрааж болдог юм байна.

### Түймэр хэзээ унтдаг вэ?



Өглөөний 9-өөс оройн 21 цаг

Түймэр дээд зэргийн эрчимтэйгээр шатна. Энэ үед унтраахад маш хэцүү



Оройн 21 цагаас үүр шөнийн 4 цаг

Шатлагын эрчим буурна. Энэ үед түймрийг унтраах ажлын бүтээмж нэмэгдэнэ.




Үүрийн 4-өөс 6 цаг

Шатлага сул явагдах бөгөөд ихэнхдээ дөл гарахгүй уугиж шатна. Түймрийг унтраахад хамгийн сайн цаг болно.



Өглөөний 6 цагаас 9 цаг

Шатлагын эрчим сул байх тул түймрийг унтраахад сайн цаг байна.





## СЭДЭВ 10. ЗУДЫН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА

### Уншаад ярилцаарай

Мал сүрэг өвөл, хаврын улиралд бэлчээр, усаар гачигдаж эцэж туран үй олноор хорогдох уур амьсгал, цаг уурын нөхцөлийг **зуд** гэнэ.

Зуд нь дараах Цагаан зуд, Шуурган зуд, Хүйтний зуд, Харын зуд, Туурайн зуд гэсэн 5 төрөлтэй байна.

### Зудын нөхцөл үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйл

#### Байгалийн хүчин зүйл

- Их цас
- Их хүйтэн
- Өмнөх зуны ган
- Хүчтэй цасан болон шороон шуурга

#### Хүний хүчин зүйл

- Бэлчээрийн буруу ашиглалт
- Малын тарга хүч муу байх
- Хэт олон тооны мал
- Өвс тэжээл, хашаа хороогоо хангалттай бэлтгэхгүй
- Залхуурал

### Зудын гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд малчид юу анхаарах ёстой вэ?

- өвс тэжээлийн нөөцийг бэлтгэх
- бэлчээрийг хамгаалах, хуваарьтай ашиглах
- малын тарга хүчийг сайн авахуулсан байх
- малчид хөдөлмөрөө хоршиж хамтлаг, нөхөрлөл байгуулж ажиллах
- малын даатгалын үйлчилгээнд хамрагдах
- дулаан хувцас, илчлэг хоол хүнс, шатахуун, түлээ, эм зэргийн нөөц бүрдүүлэх
- цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг хүлээн авах нөхцөл бүрдүүлэх, мэдээний төлөв байдалд дүгнэлт хийж аж амьдралаа зохицуулах
- малын хашаа саравч, худаг усыг дулаалах
- аян замд явахдаа тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгах, шатахууны нөөцийн бэлэн байдлыг хангах

### Орон нутгийн засаг захиргаа юу анхаарах ёстой вэ?

- малчин өрхүүдийн байршил, өвөлжилтийн судалгаа гаргаж, тэдэнтэй холбоо барих арга замыг тодорхойлсон байх
- зэргэлдээ аймаг, сумуудад цаг хүндэрсэн үед хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах
- зудын эрсдэлийг бууруулах талаар малчдад сургалт зохион байгуулах
- малчид болон жолоочид цас зудын үед осгох, уул давааны цасанд суух зэрэг болзошгүй эрсдэлээс сэргийлэх



### Хамтдаа хийцгээе



Хүүхдүүдээ та нар өөрийн амьдарч буй нутаг орондоо хэдэн онд ямар зуд болж байсан, хичнээн тооны мал сүрэг хорогдсон, зуд болоход хүргэсэн шалтгаан нь юу байсан талаар өвөө эмээ, аав ээж, нутгийн ахмад хүмүүстэй уулзан ярилцаж, орон нутгийнхаа зудын гамшгийн цаг хугацааны түүхэн зураглалыг гаргаж, энэхүү мэдээллээ найз, нөхөдтэйгээ хуваалцаарай.

#### Зудын цаг хугацааны түүхэн зураглал хийхэд ашиглах хүснэгт

Хэдэн онд вэ	Ямар төрлийн зуд тохиолдсон бэ?	Хичнээн тооны мал сүрэг хорогдсон бэ?	Өөр ямар ямар хохирол учирч байсан бэ?	Зуд болоход ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ?	Уулзаж мэдээлэл авсан хүний нэр, нас






### Үүнийг мэдэх үү



2009-2010 оны өвөл монгол орны нутаг дэвсгэрийн 80%-ийг хамарсан зуд болж 10 орчим сая толгой мал хорогдсон байна.

Зудын эрсдэлийг бууруулах нь яагаад чухал вэ гэдгийг хүүхдүүд та нар манай оронд тохиолдсон зудын гамшигт хорогдсон малын тооноос харах боломжтой.

#### малын тоо, мянган толгойгоор

Төрөл	2009	2010	Хорогдсон малын тоо
	2 221.3	1 920.3	301.0
	2 599.3	2 176.0	423.3
	277.1	269.1	7.5
	19 274.7	14 460.4	4 814.3
	19 651.5	13 883.2	5 768.3





## СЭДЭВ 11. ҮЕРИЙН АЮУЛААС ХЭРХЭН ХАМГААЛАХ ВЭ?

Уншаад ярилцаарай

Үерийн тухай ойлголт

Аадар бороо эсвэл удаан хугацаанд үргэлжилсэн зүс бороо, хайлсан цас, мөсний усны нөлөөгөөр усны түвшин эрс нэмэгдэх, ус эргээсээ халих, голын эрэг орчмын газар, хуурай сайр усанд автахыг **үер** гэнэ.

Монгол оронд 3 төрлийн үер тохиолдоно

Хур борооны үер

Уруйн үер

Шар усны үер

Үерийн аюулаас хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

- Гэр байшин, хашаа, сургуулиа үерийн усанд өртөх боломжтой эсэхийг олж мэдэх
- Хэрэв танай гар үерийн аюултай газарт байрладаг бол өөр тийшээ нүүх талаар бодож үзэхийг аав, ээждээ хэлээрэй.
- Цаг агаарын мэдээ тогтмол сонсох

Үерийн аюулын үед юу хийх вэ?

- өндөрлөг газарт байх
- үерийн уснаас хол

Үерийн дараагаар юу хийх хэрэгтэй вэ?

- эхлээд өөртөө дараа нь бусдад туслах
- эвдэрсэн газраас хол байх
- хоол хүнс, ундны усыг болгоомжтой хэрэглэх



### Хамтдаа хийцгээе



Хүүхдүүдээ та нар үерийн аюултай өөрийн биеээр таарч байгаагүй бол үерийн тухай төсөөлөх боломжгүй байгаа. Хэдийгээр чи энэ гамшгийн талаар туршлагагүй боловч гэр бүлийн чинь хэн нэгэнд энэ туршлага байх тул түүнтэй ярилцаж үерийн гамшгийн талаар илүү мэдлэгтэй болж, үерийн үед өөрийгөө болон бусдыг хамгаалах арга ухаанд суралцаж болно.

Энэхүү ярилцлагаа гэр бүлийнхээ гишүүний хамгийн тохиромжтой цагийг сонгон хийгээрэй. Та нар ярилцахдаа дараах хүснэгтийн дагуу богинохон тэмдэглэл хөтлөх хэрэгтэй. Бүлэгийн гишүүн бүрийн хийж ирсэн тэмдэглэлийг нэгтгэн хамтдаа дахин нэг хэлэлцээд үер тохиолдсон үед авах арга хэмжээ бүхий зөвлөмж боловсруулан найз нөхөд, анги хамт олон бусад хүмүүст хүргээрэй.

Он, сар, өдөр	Ярилцсан гэр бүлийн гишүүний нэр	Ярилцлагын дэлгэрэнгүй тэмдэглэл	Өөрийн дүгнэлт

### Үүнийг мэдэх үү



Үерийн усны хурд нь 4 м/сек-ээс дээш ба өндрийн түвшин нь 0.2 метрт хүрэхэд хүн, амьтны амь насанд аюул учруулна.

Үерийн усны гүн 0,6 метр байхад ямар ч машиныг хөвүүлэх чадвартай





## СЭДЭВ 12. ГОЛ, МӨРНИЙ УСНЫ ОСОЛ, ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ АРГА



### Уншаад ярилцаарай

Хүүхдүүд та нар зуны зугаатай өдрүүдэд амралт, чөлөөт цагаараа хөдөө хээр гол, мөрний эргээр амарч зугаалах, голын эрэг дээр тоглож нааддаг. Харин өвлийн цагт гол дээр гулгаж тоглох, анги хамт олноороо уралдаан тэмцээн зохиох, мөсний баяр зохион байгуулж чөлөөт цагаа өнгөрөөдөг.

Энэ үед усны осол болохоос сэргийлэх арга хэмжээг байнга авч байх хэрэгтэй шүү.

### Гол, мөрний усны ослоос хэрхэн сэргийлэх вэ?

#### Гол мөрний усанд осолдохоос урьдчилан сэргийлэх арга:

- Гол, мөрний эргийн ойролцоо байхдаа анхаарал болгоомжтой байх
- Сэлж чадахгүй бол сайн мэдэхгүй болон гүнзгий устай газар усанд орохгүй байх
- Зөвхөн сайн мэддэг газраа усанд сэлэх
- Хоол идсэний болон халуун наранд удаан байсны дараа усанд орохоос зайлсхийх
- Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх
- Хүйтэн усанд хэт удаан байж болохгүй, учир нь хөл, гарын шөрмөс татаж болзошгүй
- Аянга, цахилгаан, хүчтэй салхи шуургатай үед усанд орж болохгүй
- Гол мөрний усыг хөвөгч хэрэгслээр гатлах бол аюулгүй байдлыг хангаж зааврын дагуу ашиглах
- Усны гүнийг зөв үнэлэх

Усанд живэх үед амьсгалын замаар ус орсноос болж агаарын солилцоо алдагдснаар цусан дахь хүчилтөрөгч хүрэлцээгүй болж ухаан алддаг. Хүн усан дотор 5-6 минут болсны дараа бие махбодийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж үхэх аюултай. Иймд хүн усанд живж байвал:

- Сандарч тэвдэлгүйгээр нөхцөл байдлыг зөв үнэлж оновчтой арга хэмжээ авахыг хичээх
- Хамгийн түрүүнд живж буй хүнд хөвдөг зүйл шидэж өгөх
- Нэн даруй тусламж дуудах


### Мөс цөмрөх аюулаас хэрхэн сэргийлэх вэ?

Хэрвээ хүн мөсөнд цөмөрвөл живэх, хүйтэнд цохиулах, цаашлаад хөлдөж амь насаа алдаж болно. Аюулгүй байдлыг хангах үүднээс гол мөрний мөсний зузааныг урьдчилан мэдэх явдал юм. Мөсний зузааныг тодорхойлохын тулд түүнд нүх гаргаад хэмжиж болно.



### Мөсөнд цөмөрч амь насаа алдахаас урьдчилан сэргийлэх арга:

- мөсний нимгэн зузааныг шалгаж тодорхойлох;
- болж өгвөл мөсөн дээр гарсан жимээр явах, хэрвээ жим байхгүй тохиолдолд эрэг дээр байхдаа явах замаа сайтар товлох;
- явганаар явах үедээ гартаа томхон урт мод бариад, сэжигтэй санагдсан газрыг тойрч явах;
- мөс тас тас дуугарч, хотойж байвал хөлний хоорондын зайг нэмэгдүүлж мөснөөс салгалгүй зөөлөн алхаж маш хурдан эрэг дээр гарах;
- мөсөн дээр нэг газарт ачаа овоолох, хүмүүс олноороо бөөгнөрөхөөс сэргийлэх;
- харагдах орчин хязгаарлагдмал цастай, салхи шуургатай болон шөнийн цагаар гол мөрний мөсөөр явахгүй байх;
- мөсний бат бөхийг хэзээ ч хөлөөрөө дэвсэлж шалгаж болохгүй.



Хэрвээ мөс цөмөрч хэн нэгэн усанд унасан тохиолдолд дараах аргыг ашиглан аврах ажиллагаа явуулна.





### Живсэн хүнд анхны тусламж үзүүлэхдээ:

- Аварсан хүн ухаан алдаагүй байгаа тохиолдолд түүнийг хэвтүүлж, халуун бүлээн зүйл уулгаж сайн дулаацуулж сэтгэл санааг нь тайвшруулна
- Ухаан алдсан бол нэн даруй түүний амьсгалыг нь сэргээх. Үүнийг маш богино хугацаанд буюу 10-15 секундэд багтаан амьсгалын замыг нь усгүй болгож дээш харуулан хэвтүүлж хиймэл амьсгал эсвэл зүрхэнд иллэг хийх
- Яаралтай түргэн тусламж дуудах
- Шаардлагатай тохиолдолд нэн даруй эмнэлгийн байгууллагад хүргэх, тээвэрлэх үед хамгийн тохиромжтой байрлал болох хажуугаар нь хэвтүүлнэ.



### Хамтдаа хийцгээе

#### Хүүхдүүдээ усанд сэлж сураарай.

#### 5 хоногт усанд сэлж сурах дасгал

Эдгээр дасгалыг хийж сурхад чиний мөрний хэмжээнд хүрэх, чи чөлөөтэй хөдөлж болох ус хэрэгтэй. Усанд сэлж сурах зохилго тавьсан 5 өдөр, өдөр бүр 3-4 удаа 15 минутаар хичээллэх шаардлагатай болно.

#### Эхний өдөр:



- Усанд толгойгоо далд ортол орох хэрэгтэй. Усанд толгой орсон үед та нүдээ нээх хэрэгтэй ба амьсгалаа зөөлөн 10 тоолох хэмжээнд гаргана.
- Дараа нь усанд орохдоо амьсгалыг өмнө нь заасны дагуу усанд авахаас гадна хөлөө нугалж, өвдгөө гараараа хумиж цээжиндээ татна. Энэ үед чиний бие усан дээр хөвнө.

- Усан дээр хөвөх үед чи гар хөлөө тэнийлгэж усан дээр хөвнө.

#### Хоёр дахь өдөр:



- Хоёр дахь өдөр усанд хөвж сурсан дасгалаа санаж, давтан хийхээр энэ өдрийн дасгал эхлэнэ шүү. Хөвөх явцад чиний бие сул, нүүр чинь усанд байх ёстойг санаж байгаа биз дээ. Ийнхүү хөвөх явцдаа уснаас толгойгоо гаргалгүй амьсгалаа тайван бага багаар гаргана.
- “Даллах” сэлэлтийн аргыг энэ өдөр сурна.

Зургийн дагуу газраас өлмийгөөрөө хүч авч усанд хөвөх хүчээ авах ёстой шүү.

#### Гурав дахь өдөр:

- Усанд шумбахаас өмнө амьсгалаа гүнзгий авч түүнийгээ усанд шумбах явцдаа аажмаар гаргаж, аль болох өвдөгөө нугалалгүйгээр хөлөөрөө усаа цохиж, урагшлахыг хичээ. Амьсгалаа усан дотроо гаргахаа





мартав. Нэгэнт чи усанд хөвөөд сурсан тул гараа ээлжлэн урагш шидэж, ус хүчтэй татах хэрэгтэй. Толгой усан дотор, харин нүд нээлттэй байх хэрэгтэй. Хүмүүс усанд сэлж байгааг киноноос, өөр олон зүйлээс та нар харж мэддэг болсон тул өөрийгөө усанд сэлж байгааг мэдэрч тэдний гараа хэрхэн хөдөлгөж байсныг санаж болно шүү

дээ. Энэ дасгалыг 7-8 удаа давтна шүү.

**Дөрөв дэх өдөр:**



- Усан дотор цээж хүртлээ орж, урагш хар.
- Гарын хөдөлгөөний тусламжтайгаар урагш тэмүүл.
- Хөл гараа зэрэг хөдөлгөн урагшаа тэмүүлж сэл. Ингэхдээ амьсгалын дасгалаа мартав. Амьсгалаа барьж бага багаар гаргах хэрэгтэй шүү.

**Тав дах өдөр:**




- Даллах сэлэлт нь гар хөлийн хөдөлгөөний зохицлоор хийгдэнэ. Сэлэх явцдаа усны гадарга дээр толгойгоо хажуу тийш эргүүлэх явцад амьсгалаа авч, усанд амьсгалаа гаргана. Усанд амьсгалаа гүйцэд гаргасны дараа толгойгоо мөн усны гадарга дээр хажуу тийш эргүүлэн амьсгалаа авна.

Үүнийг мэдэх үү



Гол мөрний усны ослын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Өнгөрсөн 10 жилд гол мөрний ослын улмаас Монгол улсын хэмжээнд өртөж жилд дунджаар 100 шахам хүн амь насаа алдсан байдаг.

**Гол, мөрөн, нуурын усны ослын тоо**





## СЭДЭВ 13. ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН АЮУЛААС ХАМГААЛАХ АРГА



### Уншаад ярилцаарай

**Химийн хортой бодис** гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ.

**Химийн аюултай бодис** гэдэг нь тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, цочроогч шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ. Хүмүүс бид үйлдвэрт ашигладаг химийн хортой бодис, хог хаягдлаас эхлээд гэр орноо цэвэрлэх, үнэр дарахдаа хүртэл химийн аюултай, хортой бодисыг амьдралдаа өдөр тутам хэрэглэдэг.

Химийн бодисын ослын үед ам, хамраараа амьсгалах, химийн бодист хүрсэн тохиолдолд хэдэн настай хэнийг ч гэсэн гэмтээдэг.

### Химийн аюултай болон хортой бодисын аюулд өртөхөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

- Амьдарч буй газартаа химийн бодисын осол гарч болох нөхцөл байгаа эсэхийг олж мэдэх
- Мэргэжлийн байгууллагаас өгөх заавар, журмыг дагах
- радио, телевиз, бусад мэдээллийн хэрэгслээр мэргэжлийн хүмүүсийн өгч буй зааварчилгааг дагах
- Гадаа явж байгаа бол ослын голомтын салхины дээр зогсох. Ослын газраас хамгийн багадаа 500 метр хол зайтай байх нь зүйтэй
- Байран дотор байгаа бол цонхоо хааж, агааржуулагч, цахилгаан хэрэгслээ унтраах
- Байшингийхаа хаалга цонх, шал, тааз, хана бүгдийг битүүлэх, таглаж чигжих
- Бээлий, оймс, гутал, өмд, урт ханцуйтай цамц зэрэг биеийнхээ бүх хэсгийг хамгаалах үүднээс битүү хувцаслах



### Ослын дараа хэрхэн ажиллах вэ?

- Орон нутгийн удирдлага, мэргэжлийн байгууллагаас өгч буй ариутгал, цэвэрлэгээний зааврыг дагах
- Хордсон байж болох хүнсний зүйлийг ууж, идэхгүй байх

### Ахуйн хүрээнд ашигладаг химийн бодисын аюулаас хэрхэн сэргийлэх вэ?


Бид орон гэрт, анги танхимдаа олон янзын химийн аюултай бодисыг агуулсан эд зүйлийг хэрэглэж байдаг. Энэхүү эд зүйлийг зүй бус хэрэглэх, асгаж гоожуулсан тохиолдолд маш аюултай нөхцөл байдал үүсдэг.



<p>Цэвэрлэгээний бодис, арьс арчилгааны бүтээгдэхүүн</p> 	<p>Хортон шавжны хор, бордоо</p> 	<p>Зай, сүүн гэрэл, чийдэн</p> 
<p>Авто машины тос, тосолгооны шингэн</p> 	<p>Ахуйн хэрэглээний хий</p> 	<p>Будаг, шингэлэгч бодис, өнгөлөгч, толбо арилгагч</p> 

Ахуй хүрээнд ашигладаг химийн аюултай бодисоос өөрсдийгөө хамгаалах хамгийн шилдэг арга зам бол тухайн бүтээгдэхүүнийг хадгалах, хэрэглэхдээ зааврыг маш сайн уншиж, зааврын дагуу хэрэглэж, зөв хадгалах явдал байдаг.

Химийн аюултай бодис бүхий бүтээгдэхүүнийг хэрхэн зөв хадгалах вэ?



Химийн аюултай бодис бүхий бүтээгдэхүүний зааврыг хэрхэн тайлж унших вэ?

<p>Тэсрэмтгий</p> 	<p>Шатамхай</p> 	<p>Исэлдүүлэгч</p> 	<p>Идэмхий/ Зэврүүлдэг</p> 	<p>Хортой</p> 	<p>Аюултай/ цочроогч</p> 	<p>Байгаль орчинд аюултай</p> 
---	---	--	--	---	---	---



Химийн бодис бүхий савны дээрх тэмдэглэгээ

Гэр ахуйд хэрэглэгдэг угаалгын шингэний савны шошгон дээрх тэмдэглэгээ



### Хамтдаа хийцгээе

Ахуйн хүрээнд ашигладаг хэрэглээд дууссан бүтээгдэхүүний савыг цуглуулан, савны шошгыг хэрхэн тайлж унших заавар бүхий булан бэлтгэж, найз нөхөддөө танилцуулах, сэрэмжлүүлэх ажлыг хийгээрэй.



### Үүнийг мэдэх үү

Хүүхдүүдээ ямар тэмдэглэгээтэй хуванцар сав бидний эрүүл мэндэд хортой вэ?

Бидний хэрэглэдэг хоол, хүнс, ахуйн хэрэглээний зүйл гол төлөв хуванцар савтай байдаг. Гэтэл хуванцар материал нь хүний биед сөрөг нөлөөлөх Биспонел А гэдэг хортой бодисыг их бага хэмжээгээр агуулдаг байна. Иймд хуванцар саван дээрх дараах тэмдэглэгээгээр энэ савыг хоол, хүнсний зориулалтаар хэрэглэж болох эсэхийг таньж болох юм байна.



**Дээрх тэмдэглэгээ бүхий хуванцар савнуудыг хоол хүнс, ус хадгалах зориулалтаар ашиглаж болно.**



Харин #3, #6, #7(other) дугаар тэмдэглэгээ бүхий аливаа хуванцар савыг хоол хүнс болон ус хадгалах зориулалтаар ашиглахыг хатуу хориглоно.



(OTHER) гэсэн тэмдэглэгээтэй хуванцар савыг зөвхөн химийн бодис хадгалах, тээвэрлэхэд ашигладаг.



## СЭДЭВ 14. ТӨӨРСӨН ҮЕД ӨӨРИЙГӨӨ АВРАХ АРГА

Уншаад ярилцаарай



Хүүхдүүд хээр гадаа явахдаа төөрч үүнээсээ болж амь насаа алдах тохиолдол гардаг.

### Төөрсөн үедээ яах ёстой вэ?

- Төөрснөө мэдвэл юун түрүүнд зогсох хэрэгтэй.
- Зүг чигээ тодорхойлно. Хэрвээ зүг чигээ тодорхойлохгүй хийсэн алхам тутам чинь алдаа болж, аюулд ойртуулж болох талтай.
- Аюул, ослын дохио зөв өгч сурах хэрэгтэй.

### Төөрсөн үед зүг чиг тодорхойлох аргууд

- Соронзон орноор зүг чиг тодорхойлох арга
- Одон орноор зүг чиг тодорхойлох арга
- Газар орны шинж тэмдгээр зүг чиг тодорхойлох арга

### Соронзон орноор зүг чиг тодорхойлох арга

Хөдөө, хээр аялахдаа луужин авахаа мартуузай. Луужингаа зөв ашиглаж сураарай.

Луужингийн их биеийг зөөлөн эргүүлж, зүүний үзүүрийг N үсэгтэй давхцахад

- N-north (С-север)-хойт
- S-south (Ю-юг) –өмнөд
- E-east (В-восток)– зүүн
- W- west (З-запад) – баруун зүгийг заана.



### Одон орноор зүг чиг тодорхойлох арга

Хүүхдүүдээ та нар Алтан гадас од ямагт хойд зүгийг заадгийг мэдэх үү? Та нар Алтан гадас одыг тэнгэрт олж чадах уу?

Алтан гадас одыг олж зүг чиг тодорхойлох аргыг та нарт танилцуулья.





## Газар орны шинж тэмдгээр зүг чиг тодорхойлох арга

Өмнө үзсэн аргуудаар зүг чиг тодорхойлох боломжгүй үед газар орны шинж тэмдгээр хойд зүгийг олох олон арга байдаг. Гэхдээ газар орны аль нэг шинж тэмдгээр тодорхойлсон зүгээ бусад шинж тэмдэгүүдээр заавал бататгах хэрэгтэй шүү.

### УРГАМАЛ

Модны холтос, бул чулуу, хад цохион дээр ургасан хаг, хөвд ихэвчлэн хойд талд нь байна.

Модны холтос нь хойд талдаа зузаан, харавтар өнгөтэй байна.

Говьд бутлаг ургамлын ёроолын өмнө болон зүүн урд нь элс хуримтлагдсан байдаг

### АМЬТАН

Шоргоолжны үүр нь ямагт модны хожуулын өмнө талд байрладаг. Өмнө зүгрүү харсан тал нь их налуу байдаг.

Амьтад ихэвчлэн нүхнийхээ амсрыг салхи уруудуулж ухдаг учраас нүхнээс гарсан шороо нь урд зүгт байна.

### БАЙГАЛЬ, ЗАН ЗАНШИЛ

Манай орны нөхцөлд салхи гол төлөв баруун хойноос салхилдаг учир цасан хунгарын үзүүр зүүн урагш чиглэсэн тогтоцтой байна.

Айлын гэрийн үүд өмнө болон зүүн өмнө зүг рүү харж байрласан байдаг. Гэрийн буйр тааралдвал хаалганы байрлал ямагт урд зүгийг заана.



## Үүнийг мэдэх үү

### Төөрсөн үед аюул, ослын дохиог өгөх арга

Хөдөө хээр төөрсөн үедээ аврагчдын анхаарлыг татах янз бүрийн хэрэгсэл ашиглан дохио өгөх олон арга байдаг байна. Эдгээрээс хүүхдүүд мэдвэл зохих зармыг нь авч үзье.

#### Өдрийн цагт дохио өгөх арга

- Толь ашиглан дохио өгөх арга
  - Толийг дохио өгөх хэрэгсэл болгон ашиглахын тулд толийг нарны тусгалтай өнцөг гарган дохио хүлээн авах биет рүү /онгоц, нисдэг гэх мэт/ тусгана. Нарны тусгалтай 90° –ийн өнцөг гарган гэрлэн дохио өгч байгаа толины гэрлийн тусгал 1-2 км өндөрт нисч яваа биетээс 20-25 км, зарим тохиолдолд 40 км-т харагддаг байна.

#### Шөнийн цагт дохио өгөх арга

- Дохионы түүдэг асаах
  - Түүдгийг ил задгай, өндөрлөг, алсаас харагдахуйц газар асаавал зохимжтой. Гэхдээ заавал 3 түүдгийг хоорондоо 30-50 метрийн зайтай нэг эгнээнд эсвэл гурвалжин дүрс гарган асаана. Түүдэг бүрийг нэг хүн манаж байх ёстой.
- Гар чийдэн, автомашины гэрлээр дохио өгөх арга
  - Гэрлийг асааж унтраан ослын дохиог өгч болно.
- Лаа, тосон дэн ашиглан дохио өгөх арга
  - Гэрэл нэвтэрдэг майханд эсвэл урц маягаар болгосон модыг цагаан эсвэл цайвар даавуугаар бүтээн дотор нь лаа, дэн асаавал алсаас харагдана. Түүнчлэн лааны гэрлийг ашиглан толиор дохио өгөх боломжтой.



## Хамтдаа хийцгээе



### Мэдлэг шалгах асуулт

- 2 оролцогч О “зөв” ба х “буруу” гэсэн тэмдэгтэй самбар барьж зогсоно.
- Нэг оролцогч төөрсөн үед өөрийгөө аврах аргатай холбоотой 10 асуултыг асууна. Оролцогч энэ асуултын буруу, зөвийг ялгаж зөв, буруу гэсэн тэмдэгтэй самбар барьсан хүүхдийн өмнө хуваагдаж зогсоно.
- Зөв хариултыг сонгосон оролцогчид үлдэж дараагийн асуултад хариулах хэлбэрээр явагдана. Буруу хариултыг сонгосон оролцогчид хасагдана.
- 10 асуултын эцэст үлдсэн оролцогч ялагч болно.

## СЭДЭВ 15. ТЭСЭЖ АМЬД ҮЛДЭХ АРГА

### Уншаад ярилцаарай



### Түүдэг, гал түлэх арга

Бидэнд ой модонд явах үед түүдэг гал асаах шаардлага гардаг. Түүдэг гал асаахад юуны түрүүнд хэрэг болох хуурай, давирхайтай мөчир, хэсэгхэн хусны үйсийг ойгоос хялбархан олж болно.

Түүдэг асаахдаа салхигүй нөмөр газрыг сонгож сайтар цэвэрлэнэ. Түүдэг галаа аль болох бага хэмжээтэй асаагаарай. Салхи шуургатай үед хуурай өвс, мөчиртэй гал авалцаж ойн түймэр дэгдэж болзошгүй.

### Хүүхдүүд та нартаа 2 төрлийн түүдэг гал асаах аргыг танилцуулъя.

<p><b>Овоохой:</b> Энэ түүдэгт ямар ч төрлийн мод зохимжтой. Моднуудаа овоохой хэлбэрээр төв рүү чиглүүлэн бие биеийг нь түшүүлэн босгож өрнө. Энэ тохиолдолд модны дээд хэсэг шатах бөгөөд дөл нь тод, өндөр, халуун, халаах зурвас нь хязгаарлагдмал байна. Ийм түүдэгт мод байнга нэмэх хэрэгтэй.</p>	<p><b>Худаг:</b> Түүдгийн хамгийн түгээмэл төрөл. Урт болон зузаанаараа ижил хэмжээтэй түлээг өрж тавина. Гал асахад 2 түлээг аар тавьж, дараагийн түлээг хөндлөнгөөр нь параллелаар өрнө. Энэ өрөлт галд агаар сайн оруулж өгөх бөгөөд түлээ бүтнээрээ жигд шатна. Ийм түүдэг дөл, дулаан ихээр ялгаруулж, овоохой хэлбэрийн түүдгээс илүү том талбайг халаана. Дохио өгөхөд энэ хэлбэрийн түүдгийг ашиглаж болно.</p>
	



Түүдгээ унтраахгүй байхаас гадна түймэр алдахгүйн тулд галаа заавал манах хэрэгтэй. Буудалласан газраасаа хөдлөхийн өмнө асаасан түүдэг галаа сайн унтраана. Шаардлагатай бол ус хийж бүрэн унтраагаарай. Бүрэн унтраагаагүй гал ой, хээрийн түймэр гарах нэг том шалтгаан гэдгийг бүү мартаарай.

**Гарын доорх эд зүйлээр түр хоргодох байр буюу майхан хэрхэн босгох талаар ярилцаарай.**






### Хамтдаа хийцгээ






Гарын доорх материал ашиглан хоол, хүнсээ бэлтгэх аргад суралцагсаа. Аливаа гамшгийн үед болон гамшгийн дараа хүмүүс гэр орондоо хоол хүнсээ бэлтгэх боломжгүй болох тохиолдол гарна. Хүүхдүүд энэ нөхцөлд бэлтгэлтэй байх нь чухал юм.

Иймд гамшгийн дараах нөхцөл байдлыг тооцож, олдоц сайтай, гарын доорх эд зүйлийг ашиглан хоол, хүнс бэлтгэх аргыг бодож олоорой. Үүнийгээ туршиж үзэж, найз нөхөддөө туршлагаа хуваалцан, зааж сургаж болох юм.

#### 1. Сонин дөрвөлжин болгох



#### 2. Сонин ашиглаж таваг хийх







## Үүнийг мэдэх үү




### Ус гарган авах арга

Газарт 0,8-1,0 метр диаметртэй, 50-60 см гүнтэй нүх ухаж, ёроолд нь ус тосох сав тавина. Нүхний амсарыг нийлэг /гялгар уут/ материалаар хучиж, захыг нь агаар орохгүйгээр элс шороогоор дарна.

Нийлэг материалынхаа дунд нь чулуу тавина. Нарны туяа нийлэг материалыг чөлөөтэй нэвтрэн нүхэн доторх чийгийг ууршуулан нийлэг материалын доод талд тунадас үүсгэнэ.

Үүссэн тунадас төв хэсэгт хуримтлагдаж бэлтгэсэн саванд дусна. Энэ аргаар хоногт 1.5 литр орчим ус олборлох боломжтой боловч энэ нь газрын хөрсний чийгшилтээс шалтгаална.





## Өөрийгөө шалгаарай

### 1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үе шатуудыг зөв харгалзуулаарай.

гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах		А. урьдчилан сэргийлэх
барилга, байгууламж, үйлчилгээг хэвийн байдалд оруулах		Б. эрэн хайх аврах
хүнсээр хангах ус ундны хангалт хийх		В. хор уршгийг арилгах
яаралтай тусламж үзүүлэх		Г. сэргээн босгох
сургалт, дадлага хийх		Д. урьдчилан сэргийлэх

### 2. Дараах нөхцлүүдийг уншаад аюул, эмзэг байдал, эрсдэл гурвын аль нь вэ гэдгийг бичээрэй.

А. Таны амьдардаг газарт 7 баллын хүчтэй газар хөдлөлт болох магадлалтай. Харин амьдарч буй байшин нь 5 баллын газар хөдлөлтөд тэсвэртэй.

.....

Б. Танай аав хөдөө байдаг хамаатныдаа очихоор төлөвлөж байв. Гэтэл телевизээр тэдний амьдарч буй нутгаар хүчтэй цасан шуурга болно гэж мэдээлсэн

.....

В. Танай өвөөгийнх зун голын тохиод зусдаг. Олон хоног үргэлжилсэн устай борооны улмаас гол үерлэж эхэлсэн.

.....

### 3. Аврах ажиллагааг зөв дараалалд оруулж бичээрэй.

- Нэрвэгдэгсдийг эрэн хайх 1.....
- Аюултай бүсээс зөөж гаргах 2.....
- Амилуулах суурь тусламж үзүүлэх 3.....
- Заналхийлж буй аюулаас нь чөлөөлөх 4.....



4. Та нар хичээлийн амралтаараа гайхамшигт аялал хийж явтал автобусанд цахилгааны гэмтлээс болж гал гарч богино хугацаанд автобуснаас хүүхдүүд, үүргэвчүүдээ авч бууцгаав.

Ойролцоогоор 200-300 километр газрыг явган явж хамгийн ойр орших суурин газарт хүрэх магадлалтай.







Иймд та нар урт замыг туулж амьд гарахын тулд үүргэвчинд байх хамгийн чухал зүйлсүүдээ авч явахаар болов. Тэдгээрт юу юу ордог вэ нэрлэнэ үү?

- |        |         |
|--------|---------|
| 1..... | 8.....  |
| 2..... | 9.....  |
| 3..... | 10..... |
| 4..... | 11..... |
| 5..... | 12..... |
| 6..... | 13..... |
| 7..... | 14..... |

5. Зөв эсвэл буруу юу аль нь вэ?

1	ЗӨВ БУРУУ	Үерийн усны гүн 0,6 метр байхад ямар ч машиныг хөвүүлэх чадвартай
2	ЗӨВ БУРУУ	Утааны үнэр гарвал хэрэгцээтэй зүйлсээ аваад өрөөнөөс тайван алхаж гарах хэрэгтэй
3	ЗӨВ БУРУУ	Алтан гадас од ямагт хойд зүгийг заадаг
4	ЗӨВ БУРУУ	Онцгой байдлын алба "БИД ХАМГААЛНА, АВАРНА, ТУСАЛНА" гэсэн уриатай
5	ЗӨВ БУРУУ	Голын мөсны зузаан 15 см байхад суудлын автомашиныг даана.


6. Химийн аюултай бодис бүхий бүтээгдэхүүний тэмдэглэгээний нэрийг бичнэ үү.

1.....	2.....	3.....	4.....	5.....	6.....
					



# Хавсралт

Хавсралт 1. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөлт





## Хавсралт 2

### Удирдамж боловсруулах загвар

Удирдамж гэдэг нь аливаа ажиллагааны дүрмийг үйл ажиллагаанд хамрагдах хүмүүст зарлах албан ёсны бичиг баримт юм.

### Удирдамж бичих аргачлал

БАТЛАВ  
БАГШ

Д.БАТ

Цаасны баруун дээд буланд үйл ажиллагааг явуулахыг зөвшөөрч буй эрх бүхий хүний гарын үсэг байна.

### ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

Үйл ажиллагааны нэрийг бичнэ.

Удирдамжийг доорх хэлбэрээр бичнэ:

1. Үндэслэл

Хавар, намрын улиралд ой, хээрийн түймэр их гардаг. Энэ хавар хуурайшилт их байгаатай холбогдуулан иргэдэд сэрэмжлүүлэг хүргэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

2. Зорилго

Иргэдэд хөдөө, хээр явахдаа гал түймэр алдахаас сэргийлэх сэрэмжлүүлэг хүргэх

3. Хамрах хүрээ: бүлэггийн гишүүн хүүхдүүд, сонирхсон бусад хүмүүс

4. Хариуцах эзэн: бүлэггийн чиглүүлэгч багш С.Цэцэг

5. Хугацаа: 2015.03-2015.04

6. Хаана: Домог багийн нутагт

7. Бусад /шаардлагагүй бол бичихгүй байж болно эсвэл нэмэлт тайлбарыг энэ хэсэгт оруулна/

БОЛОВСРУУЛСАН:

Д.БОЛД

Төгсгөлд удирдамж боловсруулсан хүний нэрийг бичнэ.



### Хавсралт 3

#### ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

Хүмүүсийн дунд Төсөл гэхээр хандивлагч байгууллага, хувь хүн ямар нэг хөрөнгө юмуу эд материал өгдөг гэсэн ойлголт давамгайлж, төслийг өөриймсөгөөр хэрэгжүүлэх асуудал дутагдаж байдаг. Иймээс бид төслийн талаар зөв ойлголттой болох нь нэн чухал юм.

Тухайн орон нутгийн иргэд, сургууль, багш, сурагч цаашлаад бүлэг өөрсдөдөө тулгарч буй асуудлыг шийдэх, нөхцөл байдлаа дээшлүүлэхийн тулд төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг төсөл гэж ойлгож болно.

#### ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

- Төслийн хүрээнд хэрэгжих арга хэмжээнүүд нь төсөл хэрэгжиж дууссаны дараа үргэлжлэн үйлчилж байхуйц үр нөлөөг төслийн явцад бий болгохыг анхаарах
- Хандивлагч байгууллага төслийг шалгаруулж авахдаа хэрэгцээнд тулгуурлах биш өөрсдийн баримталдаг үзэл баримтлал, зорилгын дагуу сонгож авдаг. Тиймээс аль нэг байгууллагад төсөл бичиж хандаж байгаа тохиолдолд тухайн байгууллагатай урьдчилж сайн танилцах хэрэгтэй.
- Төслийн зорилго, зорилт тодорхой байх
- Төслийг хэрэгжүүлснээр ямар өөрчлөлт гарахыг тодорхой бичих
- Төслийг боловсруулахдаа өөрсдийн хэрэгцээ шаардлагыг тусгахын дээр олон нийтийн санал хүсэлтийг харгалзах
- Төсөл шалгаруулах шалгуурыг маш сайн судлах хэрэгтэй.
- Төсөл боловсруулахын тулд өөрийн сургууль болон бүлэгтээ тулгамдсан асуудлыг тодорхойлох шаардлагатай байдаг. Үүний тулд:
- Сургуулийн болон бүлэгт тулгамдсан асуудлыг тодорхой гаргаж ирэх. Тулгамдсан асуудлыг гаргаж ирэхдээ сургуулийн захиргаа, бүлгийн гишүүд, багш сурагчид, эцэг эхийг аль болох өргөнөөр оролцуулах.
- Урьд өмнө тухайн чиглэлээр хийгдэж байсан ажлуудыг сайтар судлах
- Ямар асуудлыг яаж шийдвэрлэх вэ? ямар өөрчлөлт гарах вэ? тухайн асуудал нь танай бүлгийн зорилго, үйл ажиллагаатай нийцэж буй эсэхийг судлах
- Бүлгийн чадавх, нөхцөл боломжид тохирсон байх
- Төсөл нь сургууль болон нийгэмд ашиг тустай байх
- Төсөл хэрэгжээд дуусахад түүнийг хэрэгжүүлсэн үйл ажиллагаа цаашид тогтвортой үргэлжлэх боломжтой байх
- Төсөл нь хууль, дүрэм журмын дагуу байх





зэргийг тодорхойлон бичнэ.

### Төслийн зорилго зорилт

Төслийн зорилго нь уг төслөөр хэрэгжүүлэх үндсэн асуудлыг тодорхойлж байдаг. Аливаа төсөлд нэг л зорилго байх ёстой. Харин тэрхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд олон тооны зорилт тавигдаж болно. Зорилт нь зорилгын нарийвчилсан хэлбэрүүд юм. Төслөөр тавигдаж байгаа зорилго бүр тодорхой судалгаа, дүгнэлтээр батлагдаж байх ёстой.

### Үйл ажиллагааны зардал/үр ашгийн тооцоо

Төслийн үйл ажиллагааны зардлын тооцооны хэсэг хамгийн чухал, хүмүүсийн анхаарлыг татдаг хэсэг гэдгийг санах хэрэгтэй. Энэ хэсэгт төслөөр хийхээр төлөвлөж байгаа үйл ажиллагааны явцад гарах зардал, орлогын хэмжээ, үйл ажиллагааг төлөвлөж харуулах ёстой. Үүнийг боловсруулахад их хэмжээний мэдээлэл, зохих мэргэжлийн бэлтгэл хэрэгтэй байдаг учир мэргэжлийн хүмүүсийн туслалцаа авах хэрэгтэй.

### Хавсралт 4. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ КАРТУУД

эрсдэлийг үнэлэх		нөөцийг бүрдүүлэх
аюулыг бууруулах		зарлан мэдээлэл дамжуулах
эмзэг байдлыг бууруулах		эрэн хайх аврах
бэлэн байдлын төлөвлөгөө хийх		яаралтай тусламж үзүүлэх
сургалт, дадлага хийх		нүүлгэн шилжүүлэх
хоргодох байраар хангах		хоол, хүнсээр хангах
ус ундны хангалт хийх		аруйн цэвэр, эрүүл ахуйг сахих
хохирлыг тооцох		хохирлыг барагдуулах
барилга, байгууламж засаж янзлах		нийгмийн үйлчилгээг хэвийн байдалд оруулах





## Хавсралт 5. Өөрийгөө шалгаарай хэсгийн хариулт

### Анхан түвшний өөрийгөө шалгах хэсгийн хариу

1. А. аюулт үзэгдэл, осол тохиолдсон  
Б. хүмүүс их хэмжээгээр өртөж хохирсон  
В. хүмүүсийн хэвийн амьдралын нөхцөл алдагдсан
2. 1-Д 2-А 3-Е 4-В 5-Г 6-Б
3. Цасан шуурга, Зуд, Ган, Үер, Аянга, Ой, хээрийн түймэр
4. 1-ЗӨВ 2-БУРУУ 3-ЗӨВ 4-БУРУУ 5-ЗӨВ
5. 1-АХУЙН ТҮЙМЭР 2-ХҮЧТЭЙ САЛХИ, ШУУРГА  
3-ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМЭР 4-АЯНГА

### Ахисан түвшний өөрийгөө шалгах хэсгийн хариу

1. 1-А, 2-Г, 3-В, 4-Б, 5-Д
2. А- эмзэг байдал Б- аюул В. эрсдэл
3. 1- Нэрвэгдэгсдийг эрэн хайх  
2 -Заналхийлж буй аюулаас нь чөлөөлөх  
3 -Амилуулах суурь тусламж үзүүлэх  
4 -Аюултай бүсээс зөөж гаргах
5. ус, хүнс, гялгаруут, сонин, бээлий, хувцас, радио, гар чийдэн, лаа, шүдэнз, хувийн бичиг баримт, эмнэлгийн тусламжийн хайрцаг
6. 1-зөв, 2- буруу 3-зөв 4-зөв 5- буруу

1-тэсрэмтгий

2- исэлдүүлэгч

3- Шатамхай

4-Идэмхий

5-аюултай цочроогч



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Аюулгүй амьдрах ухааны үндэс., I, II, III сурах бичиг, 2011
2. Онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын гарын авлага, Хүүхдийг ивээх сан, 2012
3. НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенцийн 15 дугаар зүйлийн гарын авлага, Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллага
4. Хүүхдийн оролцоо, Хүүхэдтэй ажилдаг хүн бүрт зориулсан гарын авлага, Хүүхдийг Ивээх Сан, 2010
5. О.Үржин нар., Эрэн хайх, аврах ажлын үндэс, 2012
6. Гамшгаас өөрийгөө хамгаалах арга хэмжээний зааварчилгаа, Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь төсөл, 2009
7. “Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах” сургалтын гарын авлага, ОБЕГ, Дэлхийн зөн Монгол ОУБ, 2013
8. Гамшиг ослын тухай, Гамшиг судлалын хүрээлэн, 2008
9. Аврагч Мазаалайн зөвлөмж, өрхийн гарын авлага, ОБЕГ, Дэлхийн Зөн Монгол ОУБ, 2014
10. Монгол Улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээний эмхэтгэл, Гамшиг судлалын хүрээлэн, Улаанбаатар, 2014
11. Цаг агаарын мэдээг хэрэглэх арга, Цаг агаарын урьдчилсан мэдээ гаргах, мэдээллийн дүн шинжилгээ хийх мэргэжилтний чадавхыг дээшлүүлэх нь төсөл, 2007
12. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх гарын авлага, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх төсөл, Жайка, НОБГ, 2009
13. Тоглоомын цаг, эмхэтгэсэн Д.Мөнхтулга, Ц.Эрдэнэбат, Улаанбаатар, 2008
14. REDD+Монгол оронд гарын авлага, UN-REDD хөтөлбөр, БОНХЯам, 2013
15. Личная безопасность, Меры предосторожности в повседневной жизни, Поведение в экстремальных ситуациях, Энциклопедия для детей, Москва, 2001
16. 1-2-3 of Disaster Education, European Union, ISDR-UN, Kyoto University, 2013